

НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР



2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

НЭГ: “Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүн

- 1.1. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт
- 1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- 1.3. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт
- 1.4. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

ХОЁР: Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үр дүн

- 2.1. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт
- 2.2. Монгол улсын Эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилт
- 2.3. Нийслэлийн Эдийн засаг, нийгмийн зорилтод тусгагдсан, тухайн байгууллагаас хийж гүйцэтгэх ажлын хэрэгжилт
- 2.4. Нийслэлийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт
- 2.5. Иргэдийн өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлт
- 2.6. Архив, албан бичгийн шийдвэрлэлтийн талаар
- 2.6. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл

ГУРАВ: Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

- 3.1 Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт,
- 3.2 Дүрмээр хүлээсэн үүргийн биелэлт

ДӨРӨВ. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

- 4.1. Үйл ажиллагааны ил тод байдал
- 4.2. Хэрэглэгчийн үнэлгээ

ТАВ. Бусад мэдээлэл

- 5.1. Хүний нөөцийн ил тод байдал
- 5.2 Цаг үеийн ажлын онцлогтой холбогдох бусад мэдээлэл

**НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Монгол Улсын Засгийн газрын 08 дугаар сарын 03-ны “ Нийслэлийн засаг даргын тамгын газар, захирагчийн ажлын албаны бүтэц батлах тухай” 08 дугаар тогтоол, “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” 2016 оны 08 дугаар сарын 31-ний А/635 дугаар захирамжаар Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг баталсан болно.

НЭГ. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүн

1.1. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт

Монгол Улсын Их хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д заасан 10 стратегийн зорилтыг хэрэгжүүлэн ажиллалаа. Гүйцэтгэл нь тухайн жилийн хүрсэн байх түвшинтэй харьцуулахад 70 хувьтай байна.

Бодлого чиглэл	Заалтын тоо	Зорилтын тоо	Хэрэгжилтийн хувь							Дундаж хувь
			100	90	70	50	30	10	0	
5.1. Макро эдийн засгийн бодлого	2	3			3					
5.2. Эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийн бодлого	3	7			7					
Дүн					10					70

Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэр Эмээлт уулын зүүн хөндийд арьс шир, ноос ноолуурын чиглэлээр ҮТП, Багануур дүүрэгт барилгын материал, нүүрсний гүн боловсруулалт, нанобиотехнологийн чиглэлээр ҮТП, Налайх дүүрэгт Барилгын материалын ҮТП байгуулахаар зураг төслийн болон бүтээн байгуулалтын ажлууд амжилттай хийгдэж байна. Нийслэлийн Засаг даргын “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай “ 2016 оны 08 дугаар сарын 31-ний А/635 захирамжийн дагуу Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газарт чиг үүргийн дагуу энэ ажил шилжсэн болно.

1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагаа”-ны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгагдсан бодлогын 3 чиглэлийн 4 зорилт, арга хэмжээг хяналтад аван хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Бодлого чиглэл	Зорилт, арга хэмжээ	Хувь
Нэг. Ажилтай, орлоготой монгол хүн	33.1 Зээлийн батлан даалтын санг үүсгэн байгуулж, дүрмийг батлан үйл ажиллагааг нь эхлүүлнэ.	70
	34.7 Барилгын материалын парк, бөөний худалдааны сүлжээг Замын-Үүд, Улаанбаатар хотод байгуулна.	70
2. Ноос, ноолуур, арьс ширний чиглэлээр хэрэгжүүлэх бодлого	70.2 Улаанбаатар хотын төвийн дүүргээс арьс шир боловсруулах, ноос, ноолуур угаах үйлдвэрүүдийг нүүлгэх арга хэмжээ авна.	70
7. Үйлчилгээний бизнесийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх бодлого	119.1 Улаанбаатар хот орчимд холимог тээврийн ачааны терминал ложистик төв байгуулах ажлыг эхлүүлнэ.	50
Дундаж хувь		65

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн ҮТП НИТХТ-ийн 2014 оны 149 дүгээр тогтоолоор, Налайхын Барилгын материалын ҮТП НИТХТ-ийн 2014 оны 148 дугаар тогтоолоор, Багануур ҮТП НИТХТ-ийн 2015 оны 122 дүгээр тогтоолоор тус тус байгуулагдан батлагдсан төсөв орон тоогоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Засгийн газрын 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 272 дугаар тогтоолоор Багануур ҮТП-ийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл батлагдан гарлаа.

Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн ҮТП-ийг байгуулахад нийт 3,4 тэрбум төгрөг, Налайхын Барилгын материалын ҮТП нийт 2,4 тэрбум төгрөг, Багануур ҮТП 600,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилт тус тус хийгдээд байна. 2017 оны нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах саналыг НЗДТГ-ын СБТХ-т 2016 оны 06 дугаар сарын 02-ны 01/200 дугаар албан тоотой хүргүүлээд байна.

Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр паркийн цэвэрлэх байгууламжийн урьдчилсан ТЭЗҮ, “Барилга угсралтын үеийн цахилгаан хангамжийн ажил тус тус хийгдээд байна.

Арьс ширний үйлдвэрүүдийн технологийн хаягдал усыг цэвэрлэх байгууламжийг Европын Сэргээн Босголт Хөгжлийн банкны санхүүжилтээр байгуулахаар хамтран ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд Европын Сэргээн босголт хөгжлийн банктай “Санамж бичиг” байгуулсан.

Дээрх ажлын хүрээнд Европын Сэргээн босголт хөгжлийн банкны зээл, Азийн хөгжлийн банкны зээл болон буцалтгүй тусламжаар хамтран нийт 30 сая еврогийн санхүүжилтээр энэхүү ажлыг хийхээр төлөвлөж байна. Цэвэрлэх байгууламжийн урьдчилсан ТЭЗҮ-ийг Европын Сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр боловсруулсан ба 2017 оноос бүтээн байгуулалтын ажлыг эхлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Төр ба хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Улаанбаатар хот орчимд холимог тээврийн ачааны терминал ложистик төв байгуулах ажил нь газрын төлбөрийг хэрхэн барагдуулах асуудлын улмаас хэрэгжилт нь удаашралтай байна. “Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн ложистик төв” ХХК-ийн үүсгэн байгуулагчдын хурлыг 2015 оны 05 дугаар сарын 06-ны өдөр хуралдан, газрын дуудлага худалдааны үнийг ложистик төв ашиглалтад орсноос хойш 5 жилийн дараагаас эхлэн графикайн дагуу 8 жилийн хугацаанд төлж барагдуулах саналыг ирүүлснийг Нийслэлийн зүгээс дахин хэлэлцэхээр тогтоод байна.

Нийслэлийн Засаг даргын “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” 2016 оны 08 дугаар сарын 31-ний А/635 захирамжийн дагуу Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газарт чиг үүргийн дагуу энэ ажил шилжсэн болно.

1.3. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт

Тайлант хугацаанд үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт үндэсний таван хөтөлбөр, нийслэлийн таван хөтөлбөр хэрэгжиж байна.

№	Хөтөлбөр, төслийн нэр, батлагдсан огноо, шийдвэрийн дугаар	Хугацаа	Хувь
Нэг. Үйлдвэрлэлийн салбар			
1	Монгол улсыг үйлдвэржүүлэх үндэсний хөтөлбөр, МУ-ын Засгийн газрын 2009 оны 299 дүгээр тогтоол	2009-2016	70
2	Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөр, МУ-ын Засгийн газрын 2012 оны 171 дүгээр тогтоол	2013-2016	70
3	Нийслэлийн үйлдвэрлэлийн салбарт инновацийг хөгжүүлэх дэд хөтөлбөр, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 01 дүгээр тогтоол	2010-2016	70
4	Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх нийслэлийн хөтөлбөр, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 133 дугаар тогтоол	2015-2025	70

Хоёр. Мал аж ахуйн салбар			
1	Монгол мал үндэсний хөтөлбөр, УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоол	2010-2021	70
2	Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний үндэсний хөтөлбөр, МУ-ын Засгийн газрын 2009 оны 173 дугаар тогтоол	2009-2017	70
3	Хоршоог хөгжүүлэх дэд хөтөлбөр, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 93 дугаар тогтоол	2012-2016	70
4	“Монгол мал” дэд хөтөлбөр, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 119 дүгээр тогтоол	2014-2021	70
5	Нийслэлийн эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр, НЗД-ын А/451 захирамж	2014-2023	70
Гурав. Газар тариалангийн салбар			
1	“Чацаргана” хөтөлбөр, ЗГ-ын 2010 оны 60 дугаар тогтоол	2010-2016	100
2	Нийслэл хот орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөтөлбөр, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 32 дугаар тогтоол	2014-2020	70

Тайлант хугацаанд үндэсний болон нийслэлийн хөтөлбөрийн хэрэгжилт 70 хувьтай явагдаж байна. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Аж үйлдвэрийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлж, аж үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй хууль, төрийн бодлогыг хамтран хэрэгжүүлэх зорилгоор хамтын ажиллагааны “Санамж бичиг”-ийг 2016 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр байгууллаа. Хамтран ажиллах Санамж бичгийн хүрээнд 2016-2017 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан.

“Монгол мал” үндэсний хөтөлбөр, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих”, “Тэжээл”, “Монгол мал” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Жил бүрийн төсвийн саналд хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг тусган холбогдох газарт хүргүүлдэг боловч хөтөлбөрт зарцуулагдах төсөв байхгүйгээс хөтөлбөрийн хэрэгжилт удаашралтай байна.

1.4. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 2016 онд хэрэгжүүлэх 8 үйл ажиллагаанаас 100%-3 ажил, 90%-3 ажил, 70%-2 ажил, 50%-0 ажил, 30%-0 ажил. Гүйцэтгэл нь тухайн жилийн хүрсэн байх түвшинтэй харьцуулахад 88,7 хувьтай байна.

НЗД бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт		Хувь
НЭГ. АГААР ЦЭВЭР УЛААНБААТАР		
1.2 Хөрс болон орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:	1.2.3 Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж буй үйлдвэр, байгууллагыг хотоос гадагш нүүлгэх шат дараалсан арга хэмжээг авна.	70
ХОЁР. АМИНЫ ОРОН СУУЦТАЙ УЛААНБААТАР		
2.4 Дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр:	2.4.3 Усны нөөцийн хайгуул судалгааг нарийвчлан хийж, ашиглах боломжит нөөцийг баталгаажуулан, хэмнэлттэй хэрэглээний шинэ тогтолцоог нэвтрүүлнэ.	90
ГУРАВ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ УЛААНБААТАР		
3.5. Багануур дүүргийг хөгжүүлэх чиглэлээр:	3.5.2 “Багануур” үйлдвэр, технологийн паркийн дэд бүтцийг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.	90
3.7. Налайх дүүргийг хөгжүүлэх чиглэлээр:	3.7.1 Орон нутгийн нүүрс, барилгын материалын түүхий эдийн нөөцийг түшиглэн бүх төрлийн барилгын материал, утаагүй түлшний үйлдвэрүүдийг цогцолбороор байгуулна.	70

	3.7.2 Дүүргийн төмөр зам, дэд бүтцийг ашиглан барилгын материалын бөөний худалдаа, ложистикийн төв болгон хөгжүүлнэ.	100
3.8. Эрчимжсэн МАА-н бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр:	3.8.1. Улаанбаатар хотын сүүний хэрэглээний 80%-ийг дотоодын үйлдвэрлэлээр хангана.	100
	3.8.2. Нийслэлийн Сонгино, Бөхөгийн орчмыг гахай, шувуу, загасны аж ахуй эрхлэх бүс болгон хөгжүүлнэ.	100
	3.8.3. Нийслэлийн иргэдийн төмс, хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангана.	90
Дундаж хувь		88,7

2016 онд нийслэлийн хэмжээнд 391,3 га-д төмс тариалж 4891,4 тн, 478,5 га-д хүнсний ногоо тариалж 8181,1 тн хүнсний ногоо, 170,5 га-д малын тэжээлийн ургамал тариалж 17,5 тн ургац хураан авлаа. 2016 онд манай газраас бусад төрийн болон төрийн бус байгууллагууд, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран нийслэлийн иргэдэд газар тариалан эрхлэх мэдлэг олгох чиглэлээр нийт 33 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 2169 иргэдийг хамрууллаа.

ХОЁР. Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үр дүн

2.1. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

Тайлант хугацаанд Засгийн газрын 4 тогтоол, 1 хуралдааны тэмдэглэл, НИТХ-ын 2 тогтоол, Нийслэлийн Засаг даргын 15 захирамжийг хяналтад авч хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа. Хэрэгжилтийн дундаж үнэлгээ 99.1 хувьтай байна.

№	Тогтоол, шийдвэрийн		Хэрэгжилтийн хувь							Дундаж хувь
	Нэр	Тоо	100	90	70	50	30	10	Хугацаа болоогүй	
1	Засгийн газрын тогтоол	4	2	1					1	99
2	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	1	1							
2	НИТХ-ын тогтоол	2	2							
3	НЗД-н захирамж	15	14	1						
		22	19	2					1	

НИТХТ-ийн 2015 оны 32 тоот тогтоолоор батлагдсан “Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төслийн нэгж 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс “Бэлчээрийн менежментийн төслийн нэгж” нэртэйгээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

НИТХТ-ийн 2016 оны 02 тоот тогтоолоор Нийслэлийн хөдөө аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны “Органик Монгол” ХХК-ыг “Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”-оор, Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны тариаланч Д.Мөнх-Очир, Сонгинохайрхан дүүргийн 7 дугаар хорооны тариаланч П.Бат-Эрдэнэ, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны тариаланч П.Бямбажав нарыг “Нийслэлийн тэргүүний тариаланч”-аар шалгаруулан шагнаж урамшуулсан. 100%

-Газрын даргын 2015.09.10-ны А/20 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдан түлхүүр гардуулах нөхцөлтэй НҮХААГ-16/001 тоот тендерийн урилгыг 2016.01.29-ний өдрийн Өдрийн сонин, Өглөөний сонин болон e-procurement.mn сайтанд тавьж нээлттэй тендер шалгаруулалтыг зарласан. Тендерт 8 компани оролцсоноос “Сайн констракшн” ХХК шалгарч, А/631 дугаар захирамжийн дагуу НХӨГ-т зөвлөмжийг хүргүүлсэн.

-Тог цахилгааны ажлын тендер “Эрчим Өгий” ХХК, Усан хангамжийн ажлыг гүйцэтгэх тендер “Эрдэнэдрилинг” ХХК, Фермийн хашаа, хайс барих ажлын тендер “Хан жаргалант

стоунс” ХХК-ууд тус тус шалгарч Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн.

“ХАА-н дунд оврын трактор болон хадлангийн зориулалттай тоног төхөөрөмж худалдан авах” тендерт “Энсада трактрон” ХХК шалгарч, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн даргын 2016 оны 11 дүгээр сарын 28-ний А/18 дугаар тушаалаар томилогдсон 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тоног төхөөрөмжүүдийг хүлээн авлаа.

-“Бага оврын трактор болон ХАА-н машин, тоног, төхөөрөмж” худалдан авах тендерт 4 аж ахуйн нэгж материал ирүүлснээс “Мула” ХХК, “Зүлгэнтээг агрокорпораци” ХХК-нуудын түншлэл шалгарч гэрээ байгуулсан боловч хугацаандаа бараа бүтээгдэхүүнээ нийлүүлээгүйгээс гэрээг цуцлаж, тендерийг дахин зарласан. Тус тендерт 2 аж ахуйн нэгж материал ирүүлснээс “Хаш техник” ХХК шалгарсан. Гэвч Монгол улсын засгийн газрын 2016 оны 8 дугаар сар 17-ны өдрийн хуралдаанаар, 2016 оны 8 дугаар сар 17-ноос хойш ажил үйлчилгээ худалдан авах, тендер зарлахгүй, гэрээ байгуулахгүй байхаар холбогдох байгууллагын удирдлагуудад даалгасны дагуу тендерийг цуцалсан. 90%

2.2. Монгол улсын Эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилт

Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Хувь
ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО			
Зорилт 4.Мал аж ахуй, газар тариалангийн салбарын хөгжлийг эрчимжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.			
4.1	"Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 3.2.1, 3.2.3 дахь заалт	Үржлийн цөм сүргийн малын тоог нэмэгдүүлэх	70
Дундаж хувь			70

Малын үржлийн ажлын чиглэлээр 2016 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулж, батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Үржлийн "Шилмэл сүрэг" хоршоотой зохиомол хээлтүүлгийг захиалгын дагуу гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж, жилийн эцсийн байдлаар 281 үнээ, мах- өөхний чиглэлийн Эдейлбай үүлдрийн 600 хонинд зохиомол хээлтүүлэг хийж, хээл авалт 85 хувьтай байна. Малын өвчин гарсантай холбогдуулан улсын хэмжээнд “Шилмэл мал-2016” үзэсгэлэнг аймаг, орон нутагтаа зохион байгуулах чиглэл салбарын яамнаас өгсний дагуу Нийслэлийн “Шилмэл мал-2016” арга хэмжээг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газартай хамтран тус дүүргийн 21 дүгээр хороонд 09 дүгээр сарын 20-нд зохион байгуулж, үзэсгэлэнд сүүний 23 үхэр, мах-сүүний хосолмол ашиг шимт үхэр 5, аж ахуй нэгж 3 оролцож шалгаруулалтыг явуулж, шагнаж урамшууллаа.

2.3. Нийслэлийн Эдийн засаг, нийгмийн зорилтод тусгагдсан, тухайн байгууллагаас хийж гүйцэтгэх ажлын хэрэгжилт

Нийслэлийн Эдийн засаг, нийгмийн зорилтод тусгагдсан 2016 онд хэрэгжүүлэх 20 үйл ажиллагаанаас 100%-11 ажил, 70%-1 ажил, 90%-6 ажил, 50%-2 ажил дунджаар 90,5%-тай дүгнэгдсэн байна.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2013-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗААЛТ	2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХУВЬ
НЭГ. АГААР ЦЭВЭР УЛААНБААТАР		
1.2 Хөрс болон орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:		

1.2.3 Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж буй үйлдвэр, байгууллагыг хотоос гадагш нүүлгэх шат дараалсан арга хэмжээг авна.	1-21.Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт /Эмээлтэд/ байгуулах хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулна.	70
	1-22.Арьс шир, ноос ноолуур, өлөнгийн анхан шатны боловсруулах үйлдвэрүүдэд техник, технологийн үнэлгээ хийлгэж, хотоос гадагш байршуулах арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж эхэлнэ.	100
3.2.2 Аж ахуйн ур чадвар эзэмшүүлэх сургалт, бизнес инкубаци болон төсөл хөтөлбөр боловсруулах зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээний дэмжлэг үзүүлнэ	3-26.Үндэсний үйлдвэрүүдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчилж, борлуулалтыг нэмэгдүүлэхийн тулд "Монголд үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.	100
	3-27.Арьс шир, ноос ноолуурын үйлдвэрлэлийг дэмжиж үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.	100
	3-28.Жижиг, дунд, өрхийн үйлдвэр эрхлэгчдэд аж ахуйн ур чадвар эзэмшүүлэх, чадавхижуулах сургалтыг Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа томоохон үйлдвэрүүд дээр явуулна.	100
ГУРАВ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ УЛААНБААТАР		
3.5. Багануур дүүргийг хөгжүүлэх чиглэлээр:		
3.5.2 “Багануур” үйлдвэр, технологийн паркийн дэд бүтцийг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.	3-39.Төр ба хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд АҮЯ, Багануур дүүргийн ЗДТГазар, сонирхогч аж ахуйн нэгжүүдтэй хамтран дэд бүтэц байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.	90
3.7. Налайх дүүргийг хөгжүүлэх чиглэлээр:		
3.7.1 Орон нутгийн нүүрс, барилгын материалын түүхий эдийн нөөцийг түшиглэн бүх төрлийн барилгын материал, утаагүй түлшний үйлдвэрүүдийг цогцолбороор байгуулна.	3-42.Налайх дүүргийн Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн ажлын зураг төсвийг хийлгэнэ.	90
	3-43.Налайх дүүргийн Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан, усан хангамжийн системийн бүтээн байгуулалтын ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулна.	100
3.7.2 Дүүргийн төмөр зам, дэд бүтцийг ашиглан барилгын материалын бөөний худалдаа, ложистикийн төв болгон хөгжүүлнэ.	3-44.Төр ба хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Улаанбаатар ложистикийн төв” байгуулах төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	50
3.8. Эрчимжсэн МАА-н бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх:		
3.8.1. Улаанбаатар хотын сүүний хэрэглээний 80%-ийг дотоодын үйлдвэрлэлээр хангана.	3-49.Нийслэл хот орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжинэ.	100
	3-50.Сонгинохайхан, Налайх дүүрэгт "Малын худалдааны төв" ОНӨТҮГ байгуулах ажлыг судална.	100
	3-51.Хотын орчимд өндөр ашиг шимтэй мал, амьтныг суурин хэлбэрээр үржүүлж, ашиг шимээр нь иргэдийг баталгаат хүнсээр хангах, нийслэлийн мал аж ахуй, фермерүүдийн үйл ажиллагааг сурталжилж “Шилмэл мал” үзэсгэлэн худалдааг зохион байгуулна.	100
	3-52. “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх санхүүжилтийн асуудлыг судална.	90
	3-53. Нийслэлийн мал аж ахуй эрхлэх мастер төлөвлөгөө боловсруулах судалгаа хийнэ.	50
3.8.3 Нийслэлийн иргэдийн төмс, хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангана.	3-56.Хан-Уул дүүргийн 13-р хороонд “Нийслэлийн Агропарк” байгуулах, 8 га талбайд тариалалт хийх, үйл ажиллагааг нь тогтворжуулна.	90

	3-57. Хөдөө аж ахуйн усан хангамжийг зохистой ашиглах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	90
	3-58. “Алтан намар” үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.	100
	3-59. Төмс, хүнсний ногооны тариалан эрхэлдэг иргэн, аж ахуй нэгжид хүнсний ногоо, жимс, жимсгэнийг тариалах технологийг зааж сургах, үр суулгац үржүүлэх, шинэ тарималыг нутагшуулах, шинэ техник технологийг нэвтрүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч дэмжин ажиллана.	100
	3-60. Нийслэлийн иргэдийг эрүүл, аюулгүй, шинэ ургацын ногоо, нарийн ногоо, жимс жимсгэнээр хангахын тулд хүлэмж, газар тариалан эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн ургамал хамгаалал, химийн бодис, бордооны хэрэглээг бууруулах, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хяналт тавьж, зөвлөмж өгнө.	90
4.1. Хотын аюулгүй байдлыг ханган, хэв журмыг сахиулах чиглэлээр:		
4.1.1 Архи, тамхи үйлдвэрлэх, худалдан борлуулахад тавих хяналтыг чангатгаж, хэрэглээний соёлыг төлөвшүүлнэ.	4-3.Архи, тамхины үйлдвэрлэл дэх хүнсний аюулгүй байдлыг хангуулан, дотоод хяналтыг сайжруулна.	100
Дундаж хувь		90,5

Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтод тусгагдсан ажлын биелэлт жилийн эцсийн байдлаар 89,5 хувьтай хэрэгжиж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Үйлдвэрлэл эрхлэгчдийн анхдугаар зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 191 дүгээр тогтоолын 2-ын “б” заалтыг хэрэгжүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд таниулах зорилгоор “Монголд үйлдвэрлэв - Цагаан сар” үзэсгэлэн худалдааг Аж үйлдвэрийн яам, Хүнс хөдөө аж ахуйн яамтай хамтран 2016 оны 01 дүгээр сарын 27-ноос 02 дугаар сарын 07-ны өдрүүдэд Хүннү молл, Хархорин, Монголд үйлдвэрлэв худалдааны төвүүдэд 9 дэх жилдээ зохион байгууллаа. Энэхүү үзэсгэлэн худалдаанд 450 гаруй аж ахуйн нэгж, иргэд 1580 төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож, нэг тэрбум гаруй төгрөгийн борлуулалт хийгдсэн.

Налайх БМҮТП-ийн эхний ээлжийн түр цахилгаан хангамжийн ажил хийгдэж, ээлжийн үйлдвэрүүд цахилгаан эрчим хүчээр хангагдах бүрэн боломжтой болсон. “Арт констракшн”ХХК НБМҮТП-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийж гүйцэтгэн гэрээний дагуу НЕТГ болон Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГазарт хүлээлгэн өгсөн.

Эмээлт хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний ажлын хүрээнд үндсэн цахилгаан хангамж 110/35/10-кВ, 20МВА дэд өртөөний ажлын зураг төслийг гүйцэтгүүлж дууссан. Бүтээн байгуулалтын үеийн цахилгаан хангамжийн ажил 2*800кВ цахилгаан түгээх дэд өртөө, 1.7км 06кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөл барилга угсралтын ажлыг Мегаденк ХХК гүйцэтгэж байна. Одоогоор “Дэд өртөө”-ний барилга барьж цахилгаан тоноглолыг хийсэн ба 1.7км агаарын шугамыг татах ажил 90 хувьтай явж байгаа.

Дулааны станцыг концессын гэрээгээр гүйцэтгүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд дулааны станцын ТЭЗҮ, ажлын зураг төсөл боловсруулах, дулааны станц барих ажлын даалгавруудыг боловсруулж Нийслэлийн Ерөнхий Төлөвлөгөөний газарт хүргүүлсэн. Ундны усан хангамжийн байгууламжийг концессын гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2015 оны 07 сарын 22-ны өдрийн 622 тоот эрх шилжүүлэх захирамжийн дагуу ундны усан хангамжийн ажлын зураг төсөл дууссан бөгөөд Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт хянуулж байна. Үйлдвэрийн технологийн усан хангамжийг

концессын гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын хүрээнд технологийн усан хангамжийн зураг төсөл дууссан. Трассын давхцалтай байгаа элс хайрга олборлогч компаниудтай зөвшилцөн шугамын трассын дагуух газрын захирамж гаргуулахаар Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүсэлт гаргасан.

2016 онд манай газраас нийслэлийн иргэдэд газар тариалан эрхлэх мэдлэг олгох чиглэлээр бусад байгууллагуудтай хамтран 33 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 2169 иргэдийг хамруулсан. .

2.4. Нийслэлийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Нийслэлийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж, мэдээ тайланг цаг тухайд нь холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласан. Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 23 удаа болсноос манай байгууллагад шууд хамаарал бүхий 2, цаг үеийн шинж чанартай 16 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь www.ulaanbaatar.mn вэб сайтад оруулсан.

2.5. Иргэдийн өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлт

Өргөдөл, гомдол www.smartcity.mn өргөдөл, гомдлын нэгдсэн програмд 2016 оны жилийн эцсийн байдлаар 20 өргөдөл хүсэлт бүртгэгдсэн байна.

13 хүсэлтэд хуулийн хугацаанд нь саналаа өгсөн ба 3 гомдол шийдвэрлэгдсэн 4 саналтай танилцаж хугацаанд нь хариу өгч ажиллаа.


Өргөдөл гомдлыг дараах шат дамжлагаар шийдвэрлэж байна. Үүнд:

1. Цахим системээр ирсэн өргөдлийг хүлээн авч удирдлагад танилцуулна.
2. Удирдлагын цохолтын дагуу холбогдох хэлтсийн даргад цахимаар шилжүүлнэ.
3. Хэлтсийн дарга нар холбогдох мэргэжилтэнд цохож шилжүүлнэ.
4. Мэргэжилтэн өргөдлийн хариуг удирдлагад танилцуулна.
5. Өргөдлийг тухайн эзэнд нь албан бичгээр, утсаар болон бусад байдлаар танилцуулна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх чиглэлээр хийсэн ажил:

- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хийж байна.
- Өргөдөл гомдлын хяналтын цонхыг мэргэжилтэн бүрийн компьютерт суулгасан.

Нийт 20 өргөдөл гомдол хүсэлт үүнд:



1. СХД-ийн 24 дүгээр хороо "Бумбат рашаан" гэдэг газарт байгаа хувийн малтай иргэдийг хотоос гаргана гээд 3 жил боллоо. Одоо болтол гаргаагүй байна. Нийслэлийн Захирагчийн ажлын албаны Ж.Дэлгэрсайхан, Т.Пүрэвсүрэн эдгээр хүмүүс нь "ажил ихтэй байна, Э.Бат-Үүл дарга сонгуулиас өмнө иргэдтэй тэмцэж болохгүй" гэсэн гэх юм. Хөрөнгө төсөв байхгүй гээд одоо болтол арга хэмжээ авч өгөхгүй байна. Энэ юу гэсэн үг вэ? Холбогдох газраас шалгаж, яаралтай арга хэмжээ авч өгнө үү гэсэн иргэн Ц.Ганболдын өргөдлийг хүлээн авч судаллаа. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2015 оны 85 дугаар тогтоол СХД-ийн 24 хороо нь мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүс болгосон бөгөөд уг асуудлыг хороо дүүрэг өөрөө шийдвэрлэх бүрэн боломжтой юм гэсэн хариу өгч. СХД-ийн 24-р хороон дээр дүүргийн зохих асуудал хариуцсан мэргэжилтэн хорооны удирдлага иргэдтэй уулзалт хийн асуудлыг шийдвэрлэсэн.
2. Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын дарга Г.Пүрэвсүрэн танаа: Миний бие нийслэлийн СХД-ийн 21-р хорооны нутаг дэвсгэрт, Оорцгын хөндийд 1 га талбай дээр саалийн үнээний фермерийн аж ахуй эрхэлж байна. Уг фермерээ өргөжүүлж томруулах хүсэлтэй байгаа билээ. Миний бие нэмэх талбайн байр зүйн тойм зургийг үйлдэж СХД-ийн 21-р хорооны Засаг дарга н.Баасанжавд хүсэлт гаргахад: "Таны саналыг дэмжиж байна. Та нийслэлийн холбогдох газарт хандан зөвшөөрлөө авахад миний зүгээс ямар нэгэн асуудал байхгүй" гэж хэлсэн. Иймд миний хүсэлтийг хүлээн авч миний эзэмшиж байгаа талбайн эргэн тойронд нэмж 8 га талбай олгож өгөхийг хүсье. Мөн манай аж ахуйг бэлчээр усжуулах, хамгаалах, газар тариаланг дэмжих төсөл, хөтөлбөрт хамруулан үйл ажиллагааг маань дэмжих хүсэлтийг гаргаж байна гэсэн иргэний хүсэлтийн дагуу иргэн Ганхуягтай утсаар холбогдож арга зүйн зөвлөгөө өгч газрын асуудал эрхэлсэн байгууллага болон тухайн дүүргийнхээ газрын газрын алба руу хүсэлт гаргуулахаар болов. Эрчимжсэн аж ахуй дэмжих дэд хөтөлбөрийн танилцуулав.
3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Э.Бат-Үүл танаа: ХУД-ийн 4, 5-р хорооны малын тоо толгой нэмэгдэж байна. Нисэх болон Яармаг орчмоор ногоон байгууламж хийж байгаа. Мал ихээр амьдрах нь зөв үү? Энэ асуудлаар урд нь хэд хэдэн удаа хандаж байсан боловч дорвитой арга хэмжээ авахгүй байна. Арга хэмжээ авч өгнө үү гэсэн иргэний хүсэлтээр иргэн Н.Алтанчимэгийн өргөдлийн дагуу Хан-Уул дүүргийн 4,5,6 дугаар хороодоор Дүүргийн Хөдөө аж ахуйн хариуцсан мэргэжилтэн, мэргэжлийн хяналтын улсын байцаагч, нийслэлийн үйлдвэр, хөдөө аж ахуйн эрчимжсэн мал аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн хамтран өргөдлийн дагуу 06 дугаар сарын 22 өдөр ажиллалаа. Хороодын Засаг дарга нарт мэргэжлийн хяналтын албан мэдэгдэл хүргүүлж, хориглосон бүсэд байгаа малыг зөвшөөрсөн бүс нутаг руу шилжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахаар болов.
4. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд танаа: Хотын захиргаа өөрийн гэсэн өмчит малтай, малын фермтэй болгох санал байна. Хөдөөний малчид малын үнээ их үнэтэй зарж байгаа нь хотын иргэд бидэнд хүндрэлтэй байна. Нөөцийн мах худалдаж байгаа ч энэ нь тийм ч үр дүнтэй биш байна. Тиймээс хотын иргэддээ худалдах малтай, боломжийн тогтвортой үнэтэй зардаг болгох саналтай байна гэсэн саналын хүрээнд иргэн Б.Баярсайханы саналыг 2016 оны төлөвлөгөөнд тусган ажиллаж байгаа "Нийслэлийн мал аж ахуйн мастер төлөвлөгөө"-ний төсөлд уг саналыг тусгагдсан талаар мэдээлэл өгч ажиллалаа.

5. Үйлдвэрлэлийн асуудал хариуцсан орлогч дарга Мэндбаяр овогтой Дондогдорж цаашид мэргэжил дээшлүүлэх тул ажлаас чөлөөлж өгнө үү гэсэн хүсэлтийн дагуу "Газрын даргын 2016.08.23-ны өдрийн Б/15 тоот тушаалаар чөлөөлөв.
6. Чингэлтэй дүүргийн 19-р хороо Гүнтэд байрлах манай зуслангийн хашааг тэр орчны айлууд 2014 оноос эхлэн өнөө болтол 3 жилийн турш өвөл хавар зун намаргүй эвдэж, үхрээ оруулан хашиж, зүлэг ногоог идүүлж, үхрийн баасаар хашаа дүүргэж ирсэнд гомдолтой байна гэсэн иргэн Санждоржийн хүсэлтийн дагуу Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо ар гүнт байрлах малтай айл өрхүүд нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 85 дугаар тогтоолыг танилцуулж мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс малаа зөвшөөрсөн бүс нутаг руу гаргахыг зөвлөж, мөн зуслангийн айлын хашаа руу малаа оруулахгүй байхыг зөвлөлөө. Дүүргийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хамтран ажиллав. Чингэлтэй дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтэс газар дээр очиж мал оруулсан иргэдтэй уулзаж шалгав.
7. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд танаа: Үндэсний хөгжлийн газар болон нийслэлд анх удаа "Үйлдвэрлэл, инновацийн газар" байгуулах гэж байгаатай холбогдуулан түнш экспортлогч орчны фирм, компаниудтай харилцан итгэлцэж эрсдэл үүсгэдэггүй хөрөнгө оруулалтын "Технологийн стратегийн удирдлагын" тухай санал дэвшүүлж итгэмжилсэн байдлаар хүргүүлэв гэсэн саналаар иргэн Авирмэдтэй холбогдож ирүүлсэн саналыг үйл ажиллагаандаа тусган, хамтран ажиллахаар шийдвэрлэв.
8. Эрчимжсэн мал аж ахуйн хэлтсийн тэжээл хариуцсан мэргэжилтэн Төртогтох овогтой Нарантуяа нь Сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын согуульд нэр дэвших болсон тул ажлаас чөлөөлж өгнө үү гэсэн хүсэлтээр 2016.08.25-ны газрын даргын Б/16 тоот тушаалаар чөлөөлөв.
9. Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Ц.Буянжаргал нь Төрийн албаны тухай хуулийн 30.4.2-т заасны дагуу замын зардал олгож өгнө үү гэсэн санал гаргасны дагуу төрийн албаны тухай хуулийн 30.4.2 заалтын дагуу буцалтгүй тусламж олгов.
10. Мэргэжилтэн Содцэцэг нь Төрийн албаны тухай хуулийн 30.4.2-т заасны дагуу замын зардал олгож өгнө үү гэсэн хүсэлт гаргасаны дагуу төрийн албаны тухай хуулийн 30.4.2 заалтын дагуу буцалтгүй тусламж олгов.
11. Мэдээллийн технологи, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Сайнбаяр нь Төрийн албаны тухай хуулийн 30.4.2-т заасны дагуу замын зардал олгож өгнө үү гэсэн хүсэлт гаргаж уг хүсэлтийн дагуу төрийн албаны тухай хуулийн 30.4.2 заалтын дагуу буцалтгүй тусламж олгов.
12. Мэргэжилтэн Р.Ундармаа нь Төрийн албаны тухай хуулийн 30.4.2-т заасны дагуу замын зардал олгож өгнө үү гэсэн хүсэлт гаргаж уг хүсэлтийн дагуу төрийн албаны тухай хуулийн 30.4.2 заалтын дагуу буцалтгүй тусламж олгов.
13. Эрчимжсэн мал аж ахуйн хэлтсийн дарга Т.Дэлгэрсайхан нь өвчний улмаас гадаад явж эмчлүүлэх болсон тул байгууллагын дотоод журмын 5.12 заалтын дагуу буцалтгүй тусламж олгож өгнө үү гэсэн хүсэлт гаргаж уг хүсэлтийн дагуу 2016.08.25 өдрийн газрын даргын Б/18 тушаалаар буцалтгүй тусламж олгов.
14. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд танаа: Сүхбаатар дүүргийн иргэн өндөр настан Д.Цэвэглхасүрэн нь санал хүргүүлэх тухай өргөдөл ирүүлсэн уг өргөдлийн дагуу СБД-ийн 16-р хорооны иргэн цэвэглхасүрэнтэй өөрийн биеэр уулзаж, 09 сарын 14-нд эхлэх намрын ногоон өдрүүдэд ном товхимол, гарын авлага материал болон 4-5 нэр төрлийн мод, бут борлуулах лангууг г хуваарилан өгсөн. энэ өдрүүдэд өөрийн биеэр борлуулалтаа иргэн Цэвэглхасүрэн, хүү Билгүүний хамт хийсэн.
15. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд танаа: Улаанбаатар хотод малтай айлууд их байна. Малын гоц халдварт өвчин гарах юм

бол хэн хариуцлагыг хүлээх вэ? Улаанбаатар хотод байгаа бүх малыг гаргахгүй бол халдварт өвчин гарахгүй гэсэн магадлал байхгүй байна. Энэ асуудлыг шийдэж өгнө үү гэсэн гомдлын дагуу иргэн Н.Ганболдтой утсаар холбогдож Нийслэлд мал аж ахуйн талаар баримталж байгаа бодлого, шийдвэрүүдийн талаар мэдээлэл өгч санал солилцож ажилласан.

16. Нийслэлийн Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч дарга Ж.Батбаясгалан танаа: Бид танай байгууллагаас зарласан төслийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан фермерүүд бөгөөд төслийнхөө дагуу үйл ажиллагаагаа өргөжүүлэн явуулж байгаа билээ. Салбарын хэцүү хүнд, үр дүн үзэхэд урт хугацаа шаардлагатай болон цаг үеийн байдлыг харгалзан үзэж, хамрагдсан зээлээсээ чөлөөлөх, эргэн төлөх хугацааг 3-аас дээш жилээр хойшлуулж өгнө үү гэсэн хүсэлтийн дагуу иргэн Н.Төмөрбаатартай холбогдож уг асуудлыг Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зөвлөл, гэрээ хийгдсэн нөхцөлийн дагуу шийдвэрлэх талаар мэдээлэл өгч ажиллалаа.
17. Газар тариалангийн хэлтсийн Агропарк хариуцсан мэргэжилтэн Э.Золбаяр нь жирэмсний амралтын чөлөөг үргэлжлүүлэн сунгаж өгнө үү гэсэн хүсэлт гаргасан учир хүсэлтийн дагуу 2016 оны 09 дүгээр сарын 01-ны Б/22 дугаар тушаалаар жирэмсний амралт олгов.
18. Захиргааны хэлтсийн Хүний нөөц салбарын төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Г.Болорэрдэнэ нь жирэмсний амралтын чөлөөг үргэлжлүүлэн сунгаж өгнө үү гэсэн хүсэлт гаргасан учир хүсэлтийн дагуу 2016 оны 11 дүгээр сарын 01-ний Б/27 дугаар тушаалаар Хүүхэд асрах чөлөө олгов.
19. Захиргааны хэлтсийн дарга Д.Мягмарсүрэн нь ажлын шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй тул мөнгөн урамшуулал олгож өгнө үү гэсэн хүсэлт гаргасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 06 ны Б/36 урамшуулал олгох тушаал гаргав.

Нийслэлийн Засаг даргын А/69 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалт /Шилэн уулзалт/-д ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам”-ын дагуу ажиллаж байна.

Сүүлийн хагас байдлаар манай байгууллага нийт 221 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзаж, тэдгээр хүмүүст мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

№	Хэлтэс	Уулзалтын тоо
1	Газрын дарга /Захиргааны хэлтэс/	31
2	Хүнсний үйлдвэрлэлийн хэлтэс	53
3	Эрчимжсэн мал аж ахуйн хэлтэс	29
4	Газар тариалангийн хэлтэс	108
Нийт		221

Иргэн, аж ахуй нэгжийн төлөөлөлтэй дараах асуудлаар уулзсан.

1.Газрын дарга /Захиргааны хэлтэс/

№	Уулзалтын төрөл	Уулзалтын тоо
1	Ажилд орох хүсэлтэй	4
2	Хамтран ажиллах чиглэлээр	8
3	Малын бэлчээрийн асуудлаар	9
4	Газар тариалангийн чиглэлээр чиглэлээр	10
Нийт		31

2. Хүнсний үйлдвэрлэлийн хэлтэс

№	Уулзалтын төрөл	Уулзалтын тоо
1	Үйлдвэрлэл технологийн паркийн асуудлаар	8

2	Хамтран ажиллах, зөвлөгөө мэдээллийн үйлчилгээ авахаар	15
3	Их хотын хямдрал худалдааны чиглэлээр	30
Нийт		53

3. Эрчимжсэн мал аж ахуйн хэлтэс


№	Уулзалтын төрөл	Уулзалтын тоо
1	Тэжээлийн асуудлаар	4
2	Хоршооны чиглэлээр	2
3	Үржлийн ажлын талаар	1
4	Бүртгэлийн талаар	1
5	Фермийн аж ахуй эрхлэх талаар	8
6	Тахианы аж ахуйн чиглэлээр	3
7	Шилмэл мал үзэсгэлэнгийн чиглэлээр	11
Нийт		29

4. Газар тариалангийн хэлтэс

№	Уулзалтын төрөл	Уулзалтын тоо
1	“Чацаргана”хөтөлбөр сургалтанд хамрагдах	34
2	Хүлэмж хүссэн болон хөнгөлөлттэй зээлээр авахыг хүссэн	16
3	Өрхийн ногооны тариалалт, үр авах,сургалтанд хамрагдах	33
4	Ташир, Тарвагатай, Баян-Уулын төмс хүнсний ногооны зориулалттай иргэн аж ахуйн нэгжид олгогдсон газрын гэрээ, эрх шилжүүлэх	3
5	Гадаадын төрийн болон төрийн бус байгууллагын хооронд санамж бичиг байгуулах,үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	4
6	Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдааны чиглэлээр	10
7	Худаг гаргуулах хүсэлтэй	8
Нийт		108

2.6 Архив, албан бичгийн шийдвэрлэлтийн талаар

Байгууллагын хэмжээнд 2016 онд нийт 363 бичиг явуулж, 157 бичиг ирснийг газрын даргаар цохуулан холбогдох хэлтэс, мэргэжилтнүүдэд өгөв. 2016 оны байдлаар нийт 363 бичиг бүртгэж явуулснаас 50 нь хариутай бичиг байна. Одоогийн байдлаар ирсэн 157 бичгээс 152 нь шийдвэрлэгдэж 5 албан бичиг шийдвэрлэх шатандаа байна.



Архивын заавар журмын дагуу архивын баримтыг түр олгох бүртгэл хөтлөн олгож байна. Архивын баримтын хадгалалт хамгаалалтад хяналт тавьж, ажиллаж, хадгалалтыг сайжруулах үүднээс сан хөмрөгийн чийг, дулаан хэмжих, цэвэрлэгээ үйлчилгээ хийсэн байдлыг ханган ажиллаж байна. Баримтыг нэгж бүрээр дахин өрж тавин нягтлан шалгав.

2014 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/452 дугаар захирамжийн дагуу программд шивж, оруулан байгууллагын цахим архивыг үүсгэсэн.

- 2016 оны нийт явсан бичгийг сар бүрээр ангилан, нягтлан шалгаж дутуу болон хавсралтгүй бичгийг нөхөн гүйцээж 7 сараас хойш бүх явсан албан бичгийг <http://edoc.ub.gov.mn/> програмын явсан бичгийн талбарт нөхөж бүртгэлжүүлсэн.
- 2016 оны нийт ирсэн бичгийг сар бүрээр ангилан, нягтлан шалгаж 7 сараас хойш ирсэн бичгийг <http://edoc.ub.gov.mn/> програмын ирсэн бичгийн талбарт эхлэн нөхөж бүртгэж, шийдвэрлэсэн

Хэвлэмэл хуудасны зарцуулалтад хяналт тавьж, мэдээ гаргаж ажиллаж байна.

2016 оны байдлаар хэвлэмэл хуудас		
	Зарцуулалт	Үлдэгдэл
A4	183	126
A5	811	125
Актлах		
A4		4
A5		30

2.6. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал	Хэрэгжилт
I	90 үнээний зогсоол бүхий иж бүрэн цогцолбор фермийн аж ахуй байгуулах	
I.1	Фермийн барилга	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны "Нийслэлийн 2015 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 24/04 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 32 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын "Эрх шилжүүлэх" тухай 2015 оны А/631 дугаар захирамжийн дагуу Газрын даргын 2015.09.10-ны А/20 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдан түлхүүр гардуулах нөхцөлтэй НҮХААГ-16/001 тоот тендерийн урилгыг 2016.01.29-нд өдөр тутмын Өдрийн сонин, Өглөөний сонинд болон e-procurement.mn сайтад тавьж нээлттэй тендер шалгаруулалтыг зарласан. 10 компани ТББ худалдан авснаас 8 компани материал ирүүлснээс "Сайн констракшн" ХХК шалгарч гэрээ байгуулж барилгын ажлыг гүйцэтгэсэн.
I.2	Сургалтын төвийн барилга	
I.3	Техник, тоног төхөөрөмжийн гараж, засвар үйлчилгээний төв	
I.4	Материал болон үр, бордооны агуулах	
I.5	Тэжээлийн саравч	
II	Дэд бүтцийн ажлууд	
II.1	Цахилгаан хангамж	Газрын даргын А/24 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо тус төслийн гадна цахилгааны ажлын тендер сонгон шалгаруулалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулж 3 аж ахуйн нэгжид урилга хүргүүлж, Шалгарсан "Эрчим Өгий" ХХК нь 1,5м цахилгаан эрчим хүч татаж хүлээлгэн өгсөн.
II.2	Худаг /2ш/	Үнэлгээний хорооны шалгаруулалтаар шалгарсан "Эрдэнэдриллинг" ХХК шалгарч ажлыг гүйцэтгэсэн.
II.3	Дулаан, ус хангамж	Монгол улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар сар 17-ны өдрийн хуралдаанаар, 2016 оны 8 дугаар сар 17-ноос

		хойш ажил үйлчилгээ худалдан авах, тендер зарлахгүй байх шийдвэр гарсны дагуу тус ажил хийгдээгүй.
II.4	Зам харгуй, фермийн дотоод тохижилт	Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/222 дугаар захирамжийг үндэслэн Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын даргын А/23 дугаар тушаалын дагуу уг Сонгинохайрхан дүүргийн Нарийны хөндийн Шар хоолойн аманд байрлах Фермийн барилгажих талбайн дотоод тохижилт /хашаа барих/-ын ажил, НҮХААГ-16/002 ажил нь гэрээ байгуулагдсан гүйцэтгэгч байгууллага “Хан Жаргалант стоунс” ХХК нь ажлаа хийж хүлээлгэн өгсөн.
II.5	Тэжээлийн талбай хаших хайсны зардал	
III	Хадлан, тэжээл техник тоног төхөөрөмж	
III.1	Трактор 110 м.х /110 морины хүчтэй/ 2 ш	“ХАА-н дунд оврын трактор болон хадлангийн зориулалттай тоног төхөөрөмж худалдан авах” тендерт “Энсада трактрон” ХХК шалгарч, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн даргын 2016 оны 11 дүгээр сарын 28-ний А/18 дугаар тушаалаар томилогдсон 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тоног төхөөрөмжүүдийг хүлээн авлаа.
III.2	Урдуур буулгагч /1800мм-ийн шанагатай/ 1ш	
III.3	Прессний машин /13 ширхэг хутга бүхий механизмтай/ 1ш	
III.4	Прессэлсэн өвс ороон боогч /750 маркийн полиэтилен уутанд таарах/ 1ш	
III.5	Хадуур /Дамран хадуурын ангитай, авах өргөн 3м/ 1ш	
III.6	Тармуур /Авцын өргөн 3.8м/ 1ш	
III.7	Өвс эргүүлэгч сэврээгч /Авцын өргөн 5.2 м/ 1ш	
III.8	Өвс ачих, буулгах сэрээ /3 цэгт хүлээн авагчтай гидро механизмтай/ 1ш	
III.9	Үрлэгч /Хаван үрлэх механизмтай, ажлын өргөн 3м/ 1ш	
III.10	Эрдэс бордоо цацагч машин, 2 холбогч /Ажлын өргөн 10-18м/ 1 ш	
III.11	Өтөг бууц цацагч, шингэн өтөг цацагч, холигч /6,5 тонны багтаамжтай/ 1ш	
III.12	Хөргөлтийн систем бүхий иж бүрэн автомат саалтуурын төхөөрөмж /автомат саалтуур, сүү хөргөх танк/ 1ш	
III.13	Өтөг бууц хадгалах сав 1ш	
IV	Бага оврын газар тариалангийн техник, тоног төхөөрөмж	
IV.1	Анжис /2 хошуутай, авцын өргөн нь 90-150 см/ 1 ш	“Бага оврын трактор болон ХАА-н машин, тоног, төхөөрөмж” худалдан авах тендерт 4 аж ахуйн нэгж материал ирүүлсэнээс “Мула” ХХК, “Зүлгэнтээг агрокорпораци” ХХК-нуудын түншлэл шалгарч гэрээ байгуулсан боловч хугацаандаа бараа бүтээгдэхүүнээ нийлүүлээгүйгээс гэрээг цуцалж, тендерийг дахин зарласан. Тус тендерт 2 аж ахуйн нэгж материал ирүүлснээс “Хаш техник” ХХК шалгарсан. Гэвч Монгол улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар сар 17-ны өдрийн хуралдаанаар, 2016 оны 8 дугаар сар 17-ноос хойш ажил үйлчилгээ худалдан авах, тендер зарлахгүй, гэрээ байгуулахгүй байхаар холбогдох байгууллагын удирдлагуудад даалгасны дагуу тендерийг цуцалсан.
IV.2	Роторт сийрүүлэгч /Авцын өргөн нь 2 м/ 1ш	
IV.3	Төмс үрлэгч /2 мөрөөр үрэлдэг/ 1ш	
IV.4	Хүнсний ногооны хураагч 1ш	
IV.5	Хүнсний ногоо үрлэгч 1ш	
IV.6	Төмс хураагч 1ш	
IV.7	Тусгай зориулалтын авто машин 1ш	
IV.8	Трактор /35 морины хүчтэй/ 1ш	
IV.9	Мотоблок 2ш	
IV.10	Ачааны автомашин /5тн/ 1ш	

- Газрын даргын 2015.09.10-ны А/20 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдан түлхүүр гардуулах нөхцөлтэй НҮХААГ-16/001 тоот тендерийн урилгыг 2016.01.29-ний өдрийн Өдрийн сонин, Өглөөний сонин болон e-procurement.mn сайтад тавьж нээлттэй тендер шалгаруулалтыг зарласан. Тендерт 8 компани оролцсоноос “Сайн констракшн” ХХК шалгарч, А/631 дугаар захирамжийн дагуу НХӨГ-т зөвлөмжийг хүргүүлсэн.

- Тог цахилгааны ажлын тендерт “Эрчим Өгий” ХХК, Усан хангамжийн ажлыг гүйцэтгэх тендерт “Эрдэнэдриллинг” ХХК, Фермийн хашаа, хайс барих ажлын тендерт “Хан жаргалант стоунс” ХХК-ууд тус тус шалгарч Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн.

“ХАА-н дунд оврын трактор болон хадлангийн зориулалттай тоног төхөөрөмж худалдан авах” тендерт “Энсада трактрон” ХХК шалгарч, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн даргын 2016 оны 11 дүгээр сарын 28-ны А/18 дугаар тушаалаар томилогдсон 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тоног төхөөрөмжүүдийг хүлээн авлаа.

- “Бага оврын трактор болон ХАА-н машин, тоног, төхөөрөмж” худалдан авах тендерт 4 аж ахуйн нэгж материал ирүүлснээс “Мула” ХХК, “Зүлгэнтээг агрокорпораци” ХХК-нуудын түншлэл шалгарч гэрээ байгуулсан боловч хугацаандаа бараа бүтээгдэхүүнээ нийлүүлээгүйгээс гэрээг цуцалж, тендерийг дахин зарласан. Тус тендерт 2 аж ахуйн нэгж материал ирүүлснээс “Хаш техник” ХХК шалгарсан. Гэвч Монгол улсын засгийн газрын 2016 оны 8 дугаар сар 17-ны өдрийн хуралдаанаар, 2016 оны 8 дугаар сар 17-ноос хойш ажил үйлчилгээ худалдан авах, тендер зарлахгүй, гэрээ байгуулахгүй байхаар холбогдох байгууллагын удирдлагуудад даалгасны дагуу тендерийг цуцалсан.

ГУРАВ. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан 14 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлж, тайланг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв. Дундаж гүйцэтгэл 90 хувьтай байна.

Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ	Хэрэгжүүлэх үе шат	Хэрэгжилтийн хувь						Дүгнэгдээгүй
		100	90	70	50	30	10	
Ажил үйлчилгээ 1. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийн "Эко парк" байгуулах ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ.	2	1		1				
Ажил үйлчилгээ 2. Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байгуулагдах Хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний ажлыг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулна.	4		1	3				
Ажил үйлчилгээ 3. Арьс шир, ноос ноолуурын анхан шатны боловсруулах үйлдвэрүүдэд техник, технологийн үнэлгээ хийлгэж, хотоос гадагш байршуулах арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж эхэлнэ.	1	1						
Ажил үйлчилгээ 4. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй ААН-үүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, суурьшлын бүсэд үзүүлэх орчны нөлөөллийг бууруулах арга хэмжээг авна.	1			1				
Ажил үйлчилгээ 5. Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгыг ханган ажиллана.	1			1				
Ажил үйлчилгээ 6. “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих” дэд хөтөлбөрийг боловсруулж батлуулна.	1							

Ажил үйлчилгээ 7. Үндэсний үйлдвэрүүдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчилж, борлуулалтыг нэмэгдүүлэхийн тулд "Монголд үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.	1	1						
Ажил үйлчилгээ 8. "Улаанбаатар түншлэл", "Жижиг дунд үйлдвэрлэлийн техник технологи" үзэсгэлэн худалдаануудыг зохион байгуулна.	1		1					
Ажил үйлчилгээ 10. Жижиг, дунд, өрхийн үйлдвэр эрхлэгчдэд аж ахуйн ур чадвар эзэмшүүлэх, чадавхжуулах сургалтыг Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа томоохон үйлдвэрүүд дээр явуулна.	1	1						
Ажил үйлчилгээ 11. Төр ба хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Аж Үйлдвэрийн Яам, Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар, сонирхогч аж ахуйн нэгжүүдтэй хамтран "Багануур" үйлдвэр, технологийн паркийн дэд бүтэц байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.	3		1	1	1			
Ажил үйлчилгээ 12. Налайх дүүргийн Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн ажлын зураг төсвийг хийлгэнэ	2		2					
Ажил үйлчилгээ 13. Налайх дүүргийн Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан, усан хангамжийн системийн бүтээн байгуулалтын ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулна.	3	1	2					
Ажил үйлчилгээ 14. Төр ба хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд "Улаанбаатар ложистикийн төв" байгуулах төслийг хэрэгжүүлнэ.	1				1			
Ажил үйлчилгээ 15. Архи, тамхины үйлдвэрлэл дэх хүнсний аюулгүй байдлыг хангуулан, дотоод хяналтыг сайжруулна.	2	1		1				
Ажил үйлчилгээ 16. Нийслэлийн үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллана.	3			3				
Ажил үйлчилгээ 17. Бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулна.	3	1		1	1			
Ажил үйлчилгээ 18. Нийслэлийн "Эрчимжсэн мал аж ахуй хөгжлийг дэмжих" үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.	2	3						
Ажил үйлчилгээ 19. Нийслэлийн "Монгол мал" үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	3	3						
Ажил үйлчилгээ 20. "Мал хамгаалах сангийн журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллана.	3	1						
Ажил үйлчилгээ 21. Сүүний фермийн аж ахуйд тавигдах ерөнхий шаардлага" үндэсний стандартыг холбогдох газруудтай хамтран боловсруулж, батлуулна.	2	1						
Ажил үйлчилгээ 22. Сонгинохайхан, Налайх дүүрэгт "Малын худалдааны төв" ОНӨТҮГ байгуулна.	3	2		1				
Ажил үйлчилгээ 23. Нийслэлийн мал аж ахуй эрхлэх мастер төлөвлөгөө боловсруулах судалгаа хийнэ.	1			1				
Ажил үйлчилгээ 25. Малын үүлдэр угсааг сайжруулах ажлыг зохион байгуулна.	1	1						

Ажил үйлчилгээ 26. Эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх сургалтыг зохион байгуулна.	2	2						
Ажил үйлчилгээ 27. “Нийслэлд мал аж ахуй эрхлэх” журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.	2	2						
Ажил үйлчилгээ 28. “Мал аж ахуйн хоршоодын үйл ажиллагааг дэмжих” журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.	2	2						
Ажил үйлчилгээ 29. Хөдөө аж ахуй эрхлэгчдийг урамшуулах ажлыг зохион байгуулна.	4	4						
Ажил үйлчилгээ 30. “Тэжээл” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	1	1						
Ажил үйлчилгээ 31. Нийслэл хот орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжинэ.	6	3	2	1				
Ажил үйлчилгээ 32. Шувууны аж ахуй эрхлэгчдэд эрүүл ахуйн журмын хэрэгжилтийг мөрдүүлж, зөрчлийг арилгуулж эрсдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	3	2			1			
Ажил үйлчилгээ 33. Хан-Уул дүүргийн 13-р хороонд “Нийслэлийн Агропарк” байгуулах, 8 га талбайд тариалалт хийх, үйл ажиллагааг нь тогтворжуулна.	3	1	1	1				
Ажил үйлчилгээ 34. Хөдөө аж ахуйн усан хангамжийг зохистой ашиглах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1	1						
Ажил үйлчилгээ 35. "Алтан намар" үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.	2	2						
Ажил үйлчилгээ 36. Төмс, хүнсний ногооны тариалан эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжид хүнсний ногоо, жимс, жимсгэнийг тариалах технологийг зааж сургах, үр суулгац үржүүлэх, шинэ тарималыг нутагшуулах, шинэ технологийг нэвтрүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дэмжин ажиллана.	2	2						
Ажил үйлчилгээ 37. Нийслэлийн иргэдийг эрүүл аюулгүй, шинэ ургацын ногоо, жимс, жимсгэнээр хангахын тулд хүлэмж, газар тариалан эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн ургамал хамгаалал, химийн бодис бордоны хэрэглээг бууруулах, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хяналт тавьж зөвлөгөө өгнө.	1			1				
Ажил үйлчилгээ 38. Хүнсний ногооны зоорины багтаамжийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллана.	2		1	1				
Ажил үйлчилгээ 39. Хүлэмжийн аж ахуй үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2		1	1				
Ажил үйлчилгээ 40. Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, шинээр ажлын байр бий болгоно.	7	3	3	1				
ДҮН	79	43	12	21	3	0	0	0

3.2 Дүрмээр хүлээсэн үүргийн биелэлт

1. Монгол Улсын Засгийн газрын болон нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тухайн жилийн зорилтод нийслэлийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлогыг тусгуулан батлуулж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн ажлыг зохион байгуулах

- Баянгол дүүргийн 1, 4 дүгээр хороо болон Хан-Уул дүүргийн 2, 3, 15 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх нийт 514,0 га талбайг “Үйлдвэр-1” нэгж хороолол, Баянгол дүүргийн 20

дугаар хороо, Хан-Уул дүүргийн 3, 4 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх 1118.0 га талбайд “Үйлдвэр-2” нэгж хороолол, Сонгинохайрхан дүүргийн 9, 20 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 968.0 га талбайд “Үйлдвэр-3” нэгж хороолол болгон хөгжүүлэхээр хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн ОНӨҮГ, “АРКЕТАЙП МОНГОЛИА” ХХК гүйцэтгэсэн.

- Энэ хүрээнд Улаанбаатар хотын төлөвлөлтийн Баруун-2 бүсийн Үйлдвэр 1, 2, 3-р хорооллын ерөнхий төлөвлөгөөг гүйцэтгэгч байгууллагуудтай хамтран ажиллаж, үйлдвэрүүдийн судалгаа болон шаардлагатай мэдээ мэдээллээр ханган ажиллаж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлууллаа.

- Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Аж үйлдвэрийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлж, аж үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй хууль, төрийн бодлогыг хамтран хэрэгжүүлэх зорилгоор Хамтын ажиллагааны Санамж бичгийг 2016 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан. Хамтран ажиллах Санамж бичгийн хүрээнд 2016-2017 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулан холбогдох газруудаас санал авч, төлөвлөгөөг Аж үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга, НЗД-ийн Экологи ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч нар хамтран баталсан.

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн нийгэм, эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх талаар хэрэгжүүлэх ажлын саналыг боловсруулж "Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих" дэд хөтөлбөрийг 4 зорилтын хүрээнд 34 ажлыг хийж хэрэгжүүлэхээр боловсруулж, батлуулан ажиллаж хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэж ажиллалаа.

Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/920 дүгээр захирамжаар “Сүүний үхрийн фермийн аж ахуйд тавих ерөнхий шаардлага” үндэсний стандартын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан стандартын төслийг 3 цувралаар боловсруулан ажиллаж байна. Төслийн эхний хэлэлцүүлгийг 4, 12 дугаар сард зохион байгуулж, төслийг техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэхээр өргөн бариад байна.

Нийслэлийн мал аж ахуй эрхлэх мастер төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг байгуулахаар 6 дүүргээс санал авч, ажлын танилцуулга, захирамжийн төслийг боловсруулан холбогдох газруудаас санал авч, Засаг даргын 2016 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/463 дугаар захирамжаар ажлын хэсгийг байгуулан хариуцах ажлын чиглэлээр судалгааны асуулгыг боловсруулан ажиллалаа.

2. Нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан үйлдвэржүүлэлт, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалантай холбоотой төсөл хөтөлбөр, түүний зураг төсөл, техникийн даалгаврыг хянаж санал оруулах

- Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/836 дугаар захирамжийн дагуу “Налайх дүүргийн Үйлдвэр технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Арт Констракшн ХХК-иар гүйцэтгүүлэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлуулсан.

- "Замын барилга байгууламж" ХХК Нийслэлийн Авто Замын газартай 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр 119.891.000 төгрөгийн дүнтэй Түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ байгуулсан. Сайжруулсан шороон замын зургийг батлуулан, гэрээний дагуу ажлыг хийж гүйцэтгэн, улсын комисст хүлээлгэн өгч, ашиглалтад оруулахад бэлэн болсон.

- Налайх дүүргийн Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн үндсэн цахилгаан хангамжийн зураг төсвийг “Баясах төгс” ХХК хийж гүйцэтгэн, гэрээний дагуу 2016 оны 03 дугаар сарын 22-нд Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, НБМҮТП-т хүлээлгэн өгсөн.

- Бат-Инспайрин ХХК паркийн талбайд 43.971.522 төгрөгийн дүнтэй 2 гүний худгийн ажлыг хийж гүйцэтгэхээр Нийслэлийн хөрөнгө оруулалтын газартай 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 2016 оны 07 дугаар сарын 25-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгч, ашиглалтад оруулахад бэлэн болоод байна.

- “ЭХО ПЛАНЕТ” ХХК байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 70% байна.

- Паркийн эхний ээлжийн түр цахилгаан хангамжийн ажил гүйцэтгэх сонгон шалгаруулалт хийгдэж, Эко повер прожект ХХК-тай гэрээ байгуулан ажилласан бөгөөд гүйцэтгэгч тал эрчим хүч авах тэжээлийн эх үүсвэрээс паркийн талбай хүртэл 3 км газарт өндөр хүчдэлийн шон байрлуулж улсын комисст хүлээлгэн өгч эхний ээлжийн үйлдвэрүүд цахилгаан эрчим хүчээр хангагдах бүрэн боломжтой болсон. Захиргааны түр байрыг оффис нэг цэгийн үйлчилгээний барилга хэлбэрээр 672 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр "ИЗО ХАУС" ХХК гүйцэтгэж, халаалтын шугамуудыг холбон, улсын комисст хүлээлгэж өгсөн. НБМҮТП-ийн цэвэрлэх байгууламж, эрчим хүчний эх үүсвэрийн шугамыг концессын гэрээгээр гүйцэтгүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулж Эдийн засгийн хөгжлийн газарт хүргүүлсэн. Эдийн засгийн хөгжлийн газрын 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/238 дугаар албан бичгээр цэвэрлэх байгууламж барих төслийг эрчим хүчний эх үүсвэрийн шугамын хамт барих төслөөс салгаж, нэр өөрчлөн дангаар нь тусгахаар болсон тухай мэдэгдсэн. Эрчим хүчний эх үүсвэрийн шугамыг барих төсөл нь барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх төрөлтэй батлагдсан боловч эрчим хүчний эх үүсвэрийн шугамын хамт барих нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1999 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар зөвлөмжийн 1 дүгээрт эрчим хүч дамжуулах үндсэн сүлжээг төрийн өмчид үлдээх тухай заасны дагуу дээрх төрлөөр хэрэгжүүлэх боломжгүй гэсэн хариу ирүүлсэн.

- Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн паркийн үндсэн цахилгаан хангамж 110/35/10-кВ, 20МВА дэд өртөөний ажлын зураг төслийг гүйцэтгүүлж дууссан. Эрчим хүчний тухай хуулийн 14.4, Үндэсний аюулгүй зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг үндэслэн НИТХТ-ийн 2016 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 73 дугаар тогтоолоор 110/35/10 кВ-ын үндсэн цахилгаан хангамжийн ажлыг нийслэлийн концессын зүйлийн жагсаалтаас хассан.

- Бүтээн байгуулалтын үеийн цахилгаан хангамжийн ажил 2800 кВ цахилгаан түгээх дэд өртөө, 1.7 км 06 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөл, барилга угсралтын ажлыг Мегаденк ХХК гүйцэтгэж байна. Одоогоор “Дэд өртөө”-ний барилгыг барьж, цахилгаан тоноглолыг хийсэн бөгөөд 1.7 км агаарын шугамыг татах ажил 90 хувьтай байна. 2016 оны 06 дугаар сард түр цахилгаан хангамжийн ажлыг хүлээн авахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

- Дулааны станцыг концессын гэрээгээр гүйцэтгүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд дулааны станцын ТЭЗҮ, ажлын зураг төсөл боловсруулах, дулааны станц барих ажлын даалгавруудыг боловсруулж Нийслэлийн Ерөнхий Төлөвлөгөөний газарт хүргүүлсэн.

- Ундны усан хангамжийн байгууламжийг концессын гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2015 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 622 дугаар эрх шилжүүлэх захирамжийн дагуу ундны усан хангамжийн ажлын зураг төсөл дуусч, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраар хянуулж байна.

- Технологийн усан хангамжийн зураг төсөл дуусч, трассын давхцалтай байгаа элс хайрга олборлогч компаниудтай зөвшилцөн шугамын трассын дагуух газрын захирамж гаргуулахаар Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүсэлт гаргаад байна.

- “Эмээлт хөнгөн үйлдвэрийн ҮТП-ийн техник технологийн түвшний үнэлгээ”-г ШУТИС-ийн Бизнес удирдлага, хүмүүнлэгийн сургуулиар гүйцэтгүүлэн эцсийн тайланг 2016 оны 02 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авсан.

- Багануур ҮТП-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл Засгийн газрын 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 272 дугаар тогтоолоор батлагдан гарсан.

- ҮТП-ийн дэд бүтцийг барьж байгуулахад тодорхой дэс дараалсан бодлогын баримт бичгүүдийг боловсруулах шаардлагатай тул Багануур дүүргийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан ҮТП-ийн нарийвчилсан ТЭЗҮ бодлогын баримт бичиг дээр үндэслэн “Паркийн хэсэгчилсэн төлөвлөгөө”, “Паркийн дэд бүтцийн ажлын зураг”-ийг хийх санхүүжилтийг нийслэлийн төсөвт тусгуулахаар саналыг 2016 оны 06 дугаар сарын 02-ны 01/200 дугаар албан бичгээр НЗДТГ-ын СБТХ-т хүргүүлсэн. Багануур Үйлдвэрлэл, технологийн парк ОНӨҮГ нь дэд бүтцийн урьдчилсан судалгаа, тооцоог гаргаад байна.

- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2008 оны 144 дүгээр тогтоолоор Багануур дүүрэгт Үйлдвэрлэл Технологийн паркийг байгуулах газрын бүсийг /403,3 га газар/ тогтоосон хэдий ч дээрх бүсэд суурьшлын бүс суурьшиж, төлөвлөлт хийхэд бэрхшээлтэй болсон тул Багануур дүүргийн Ерөнхий төлөвлөгөөний төсөлтэй уялдуулан дахин төлөвлөлтийг хийж, НӨХГ-ын газар зохион байгуулалтын 2016 оны 04 дүгээр сарын хурлаар хэлэлцэгдэн дэмжигдэж, Нийслэлийн Засаг даргын 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/447 тоот захирамжаар Багануур дүүргийн газрын асуудал шийдвэрлэгдлээ.

“Малын худалдааны төв” ОНӨҮГ-ын дүрмийн төслийг боловсруулан холбогдох газруудаас санал авч тусган, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна. Мөн уг ажлыг хэрэгжүүлэхээр Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулан ажиллалаа.

Мөн 85 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн 2015 оны 30/23 дугаар тогтоолоор иргэдэд гэр бүлийн зориулалтаар өмчлүүлэх 68 байршлын 48 байршил нь мал аж ахуй эрхлэх бүстэй давхацсан тул уг асуудлыг Нийслэлийн удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр ажиллалаа. Жилийн эцсийн байдлаар 1200 малыг хориглосон бүсээс гаргаж ажиллалаа.

3. Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан үйлдвэржүүлэлт, хөдөө аж ахуйн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулна

- Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Улаанбаатар хотын эдийн засгийн стратегитай уялдуулан 2017 оны улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын саналыг боловсруулан 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 01/201 дүгээр албан бичгээр НЗДТГ-ын СБТХ-т хүргүүлсэн.

- Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэр Эмээлт уулын зүүн хөндийд арьс шир, ноос ноолуурын чиглэлээр ҮТП, Багануур дүүрэгт барилгын материал, нүүрсний гүн боловсруулалт, нано биотехнологийн чиглэлээр ҮТП, Налайх дүүрэгт Барилгын материалын ҮТП-уудад зураг төслийн болон бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэхээр саналаа НЗДТГ-ын СБТХ-т 2016 оны 6 сарын 02-ны 01/200 дугаар албан тоотоор хүргүүлсэн.

- Нийслэлийн Засаг даргын 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/23 дугаар захирамжаар Налайхын барилгын материалын үйлдвэр, технологийн паркийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийхэд 180,0 сая төгрөг, гүний худаг /2ш/ 44,0 сая төгрөг, Нийт 224,0 сая төгрөгийг Нийслэлийн төсөвт суулгасан. 2016 оны төсвийн тодотголд Эмээлт ХҮҮТП-д 700,0 сая төгрөг батлагдсан.

- “Цогцолбор ферм байгуулах”, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр, “Монгол мал” дэд хөтөлбөр, “Нийслэлд мал аж ахуй эрхлэх” журмын төсвийн төслийг боловсруулан, үр өгөөжийг тооцон Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар болон Япон улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага JICA-ийн төслийн багт холбогдох материалын хамт хүргүүллээ.

- Нийслэлийн засаг даргын 2016 оны А/222 тоот захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2015-2016 онд санхүүжих Нийслэлийн хот орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төсвийн эрх шилжсэн.

4. Нийслэлийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарын мэдээллийн санг бүрдүүлж, түүний баяжилтыг тогтмолжуулна

- Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогчийн 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрүүдэд тулгамдаж байгаа асуудлын тухай санал асуулгыг 02 дугаар сарын 25-ны өдрөөс 03 дугаар сарын 16-ны өдрүүдэд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 250 үйлдвэрийг хамруулан явуулсан. Судалгааны дүнг нэгтгэн, тайлан мэдээг 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хуралд танилцууллаа.

- 2015 оны 122 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2015 оны ноосны урамшуулалд хамруулахаар 6 дүүргийн 245 малчны 62089.0 кг ноосны материалыг бүрдүүлэн Мал хамгаалах санд хүргүүлж, 232 малчинд 59.265,000 урамшуулал олгогдсон. ЗГ-ын 394 дүгээр тогтоолын дагуу арьс, ширний урамшуулалд мал бүхий 6 дүүргийн 149 малчны 2974 бодын шир, 9055 богийн арьсны 71.775.000 төгрөгийн урамшууллыг олгуулах ажлыг зохион байгууллаа. Урамшуулалд хамрагдах малчдын материалд тулгалт хийж, программд оруулан ХХААЯ-ны Мал хамгаалах санд хүргүүлэн ажиллалаа.

- Тариалалт мэдээг долоо хоног бүр дүүрэг, таримлын төрөл бүрээр авч шинэчлэн холбогдох дээд байгууллагуудыг мэдээ мэдээллээр ханган ажиллав. Ил талбай болон хамгаалагдсан хөрсний таримал, жимс, жимсгэний тариалангийн мэдээ, хөдөө аж ахуйн техник тоног тоног төхөөрөмж болон усалгаатай газар тариалангийн судалгааг гарган шинэчилсэн.

5. Үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт олгосон гадаадын зээл тусламжийн хөрөнгийг нийслэлийн үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилгод ашиглах асуудлыг холбогдох дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэн зохицуулах

- Арьс ширний үйлдвэрүүдийн технологийн хаягдал усыг цэвэрлэх байгууламжийг Европын Сэргээн Босголт Хөгжлийн банкны санхүүжилтээр байгуулахаар хамтран ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд Европын Сэргээн босголт хөгжлийн банктай “Санамж бичиг” байгуулсан.

- Дээрх ажлын хүрээнд Европын Сэргээн босголт хөгжлийн банкны зээл, Азийн хөгжлийн банкны зээл болон буцалтгүй тусламжаар хамтран нийт 30 сая еврогийн санхүүжилтээр энэхүү ажлыг хийхээр төлөвлөж байна. Цэвэрлэх байгууламжийн урьдчилсан ТЭЗҮ-ийг Европын Сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр боловсруулсан ба 2017 оноос бүтээн байгуулалтын ажлыг эхлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

- УБ хотын хөгжлийн корпорацитай хамтран “Улаанбаатар хөгжил” бизнес форумыг 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Блю Скай зочид буудалд зохион байгууллаа. Уулзалт нь УТП-ийн менежмент, хөрөнгө оруулалт болон паркийн хөгжлийн асуудлаар Засгийн газар, олон улсын байгууллагын түвшинд нэгдсэн нэг ойлголттой болоход ихээхэн хувь нэмрээ орууллаа.

- “Нийслэл хот орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” хөтөлбөр батлагдсаны дагуу нийслэлийн 2 дүүрэгт, 1 үе шаттай 2014-2020 онуудад хэрэгжиж байна.

6. Улаанбаатар хотын хөгжил, эрэлт хэрэгцээнд нийцсэн ажлын байрыг бий болгох арга хэмжээг төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх

- Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Багануурын үйлдвэрлэл технологийн паркуудын үйл ажиллагаа эхэлснээр нийт 15,0 мянган ажлын байр бий болох тооцоолол гарсан. Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэ, Монголын арьс, ширний холбооны ерөнхийлөгч Б.Энх-Амгалан нар паркийн үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.

- Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэж буй иргэдэд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх технологийн мэдлэг олгох сургалтуудыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үе шаттайгаар зохион байгууллаа. 2016 оны жилийн эцсийн байдлаар 33 сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 2169 иргэдийг хамрууллаа. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх талаар мэдлэг олгосноор өрх хэрэгцээт төмс, хүнсний ногоогоор тариалхаас гадна өрхөд ажлын байр бий болох, өрхийн орлого нэмэгдэх зэрэг олон талын ач холбогдолтой.

7. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг үйлдвэрийн газруудад Монгол Улсын хууль тогтоомж, норм норматив, дүрэм, журмын дагуу үйл ажиллагаагаа явуулахад нь арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг хангуулж, гарсан зөрчлийг арилгах асуудлыг холбогдох байгууллагуудад нь уламжлан, хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлүүлэх

- Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 16 архины үйлдвэрээс 2016 онд хэрэглэх 6132 тн спитрийн тооцоог хүлээн авч нэгтгэн ХХААЯаманд албан бичгээр хүргүүлсэн.

- 2016 онд тусгай зөвшөөрөл сунгуулах 15 хүсэлт ирсэн. Архины тусгай зөвшөөрөл 10 үйлдвэр, Шар айрагны 2 үйлдвэр, тамхины 1, спиртийн 3, тамхины импортын үйл ажиллагаа эрхэлдэг 2 үйлдвэр, нийт хүсэлт гаргасан 13 үйлдвэрийн тусгай зөвшөөрлийг газар дээр нь очиж хяналт шалгалтыг холбогдох газруудтай хамтран хийж, зохих журмын дагуу сунгах дүгнэлтийг ХХААЯаманд хүргүүллээ. Архины 2 үйлдвэрийг шаардлага хангаагүйн улмаас албан шаардлага өгч зөрчлийг арилгуулахаар болсон. 2016 оны 11 дүгээр сарын 18-ны А/811 дугаар захирамжаар Согтууруулах ундааны болон тамхины үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, тэдгээрийн үйлдвэрлэл болон тамхины импортын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулсан.

- НҮХААГ, НМХГ, "Монбио фарм" ХХК, "М-Си -Эс Азия Пасифик Брюэри" ХХК-иудтай хамтран 2016 оны 05 дугаар сарын 06-ны өдөр согтууруулах ундааны үйлдвэрлэлд мөрдвөл зохих хууль тогтоомж дүрэм журам, стандартыг сурталчлан таниулах, үйлдвэрлэлд учирч болох эрсдэлүүд, түүнээс урьдчилан сэргийлэх арга замуудын талаар сургалт зохион байгуулсан. Сургалтанд нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 11 согтууруулах ундааны үйлдвэрийн дарга, чанарын менежер лабораторийн шинжээч нар оролцлоо.

- Уул уурхайн салбарын ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлын талаар төр ба хувийн хэвшил, иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, уул уурхайн оролцогч талуудын харилцан ойлголцол, хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих зорилгоор 2016 оны 04 дүгээр сарын 29-ий өдөр Налайх дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж болон иргэний нийгмийн байгууллагуудад "Уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын олон талт хэлэлцүүлэг, уул уурхайд тулгарч буй асуудлууд" сэдэвт хэлэлцүүлгийг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт 30 гаруй иргэн, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллагын төлөөлийг хамруулсан.

- Нийслэлийн нутаг дэвсгэр дэх хайрга, дайрга олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын даргын 2016 оны 05 дугаар сард баталсан 02-01/154 тоот удирдамжийн хүрээнд 2016 оны 05 сарын 15-наас 07 сарын 30-ны хооронд тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлдвэрлэл эрхлэгчдийн технологийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний чанар, үйлдвэрийн орчны нөхцлийг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сахиулах болон холбогдох хуулиуд, тэдгээрт

нийцүүлэн гаргасан дүрэм, стандартын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид ордыг зөв технологээр зохистой ашиглах, эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийлгэх, ажилчдын ажиллах нөхцлийг сайжруулах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахад чиглэдсэн хяналт шалгалтыг холбогдох газруудтай хамтран явуулж байна. Нийт 32 аж ахуйн нэгж хамрагдахаас одоогийн байдлаар 8 аж ахуйн нэгж хамрагдаад байна. Үүнээс үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болсон талаар “Эн Эс Ар”ХХК нь албан тоотыг ирүүлсэн. “Гантиг уул”ХХК, “Богдохолдинг”ХХК, “Эсто”ХХК, “Эслет”ХХК, “БТМГ”ХХК –уудад албан шаардлага өгөөд байна. Налайх дүүрэгт шавар, элс олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хийж байгаа хяналт шалгалт үргэлжилж байна.

8. Хотын хөгжлийн хэтийн төлөв, бодлогод тусгагдсан үйлдвэржүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэл, дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах

- Улаанбаатар хотын зүүн талд, Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд холимог тээврийн ачааны терминал ложистик төв байгуулах 130 га газрын эзэмших эрхийг “Туушин” ХХК-иас “Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн логистик төв” ХХК-д шилжүүлэх явцад уг газрын дуудлага худалдааны анхны үнэ болох 14,3 тэрбум төгрөгийн төлбөрийг төлж барагдуулах асуудлыг нийслэлийн Өмчийн харилцааны газраас тавьсан. “Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн логистик төв” ХХК-ийн үүсгэн байгуулагчдын хурлаар газрын дуудлага худалдааны үнийг логистик төв ашиглалтанд орсноос хойш 5 жилийн дараагаас эхлэн графикийн дагуу 8 жилийн хугацаанд төлж барагдуулах санал ирүүлсэн бөгөөд дээрх газрын 2013 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртлэх хугацааны төлбөрийн үнэ болох 185 сая 900 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулах асуудлын улмаас хэрэгжилт нь удаашралтай байна. 2016 оны 02 дугаар сарын 03-нд төлбөр барагдуулж, газар эзэмших эрх шилжүүлэх ажлын талаар уулзалт хийхэд эдийн засгийн өнөөгийн байдалд одоогоор төлж барагдуулах боломж муу, хөрөнгө оруулж хамтран ажиллах сонирхолтой гадаадын хөрөнгө оруулагч компаниуд саналаа буцаан авсан гэсэн тайлбарыг ирүүлсэн тул ажил зогсонги байдалд байна.

- “Монголд үйлдвэрлэв - Цагаан сар” үзэсгэлэн худалдааг Аж үйлдвэрийн яам, Хүнс хөдөө аж ахуйн яамтай хамтран 2016 оны 01 дүгээр сарын 27-ноос 02 дугаар сарын 07-ны өдрүүдэд Хүннү молл, Хархорин, Монголд үйлдвэрлэв худалдааны төвүүдэд 9 дэх жилдээ зохион байгууллаа. Энэхүү үзэсгэлэн худалдаанд орон нутаг, нийслэлээс Хүнс, ноос, ноолуур, арьс шир, хэвлэл, оёдол, бэлэг дурсгал, гоёл чимэглэлийн салбарын нийт 450 гаруй аж ахуйн нэгж, иргэд 1580 төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож, нэг тэрбум гаруй төгрөгийн борлуулалт хийсэн.

- Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 06 дугаар тушаалын 03 дугаар хавсралтаар баталсан шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах хорооны 2016 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хурлын шийдвэрээр Хүнсний салбарын шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр “БэцБаун” ХХК, “Витафит” ХХК. Арьс, ширний салбарын шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр “Мэргэнтур” ХХК, “Морьт хас арьсан эдлэлийн үйлдвэр”. Ноос, ноолуурын салбарын шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр “Блюскайкашемир” ХХК, “Нэхээсгүй эдлэл” ХК. Оёмол, сүлжмэлийн салбарын шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр “Хэрокин” ХХК, “Өлзий оёдлын цех”. Гоёл, бэлэг дурсгалын салбарын шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр “Бүрэнсүх”ХХК, “Уянгацогт-Амгалан” ХХК-иудыг тус тус шалгаруулсан.

- “Монголын Бараа Бүтээгдэхүүний Олон Улсын Үзэсгэлэн” худалдааг МҮХАҮТ, Аж үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яамтай хамтран 2016 оны 06 дугаар сарын 9-13-ны өдрүүдэд Мишээл экспо төвд амжилттай зохион байгуулсан. Энэхүү үзэсгэлэн худалдаанд ОХУ, Казахстан, Малайз, Унгар, БНАСАУ болон дотоодын 90 гаруй аж ахуйн нэгж оролцсон.

- Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол ногоо” төсөлтэй хамтран нийслэлийн 3 дүүрэгт “Жишиг гудамж” байгуулагдан 61 өрхийг хэрэгцээт төмс, хүнсний ногоо тариалах бүхий л нөхцөл боломжоор хангагдлаа. Мөн тус дүүргүүдэд 3 сургуулийг сонгон “Эко сургууль”, 3 цэцэрлэгийг сонгон “Эко цэцэрлэг”-ийн дэмжлэг үзүүлэн хүлэмж болон шаардлагатай багаж тоног төхөөрөмж, үр үрслэг, суулгацын дэмжлэг үзүүлэн мэргэжил арга зүйн зааварчилгаа өгч ажиллалаа.

9. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн үйлдвэржүүлэлтийн бодлогын хэрэгжилтийн биелэлтийг нэгтгэн гаргахад шаардагдах судалгаа, тооцоо, мэдээллийг Захирагчийн ажлын албаны хэлтэс, дүүргийн Засаг даргын Тамгын газар, харьяа байгууллага, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжүүдээс гаргуулан авч, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах

- Хөдөө аж ахуйн зориулалтаар гэрээгээр газар ашиглаж буй газар тариалангийн чиглэлийн 143 иргэн, 37 аж ахуй нэгж, ферм, мал бордох чиглэлээр 10 иргэн, 14 аж ахуйн нэгжээс Баян-Уулын болон Таширын амны төмс, хүнсний ногооны зориулалтаар олгосон талбайгаас 83 иргэн, аж ахуйн нэгжийн 215.0 га-г эрх шилжүүлэх, 88 иргэн, аж ахуйн нэгжийн 176.5 га-г цуцлах тухай саналыг ЗАА-д хүргүүлсэн. Улмаар Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2016 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/38 дугаар тушаалын дагуу ажлын хэсэгт ажиллалаа. Шинээр гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгжид Кадастрын зураглалын “Тэнхлэг-Уул” ХХК-аар зураглал болон эргэлтийн цэгийн актыг хүлээлгэн өгсөн.

Нийслэлийн 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Нарийний хөндийн Шар хоолойн аманд 500 га газрыг Дүүргийн тусгай хэрэгцээнд авч улмаар хөтөлбөр хэрэгжиж байна. Мөн Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо Хуандайн аманд Төмс, хүнсний ногоо тариалах, фермерийн аж ахуйн зориулалтаар 5 га, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Тарвагатайн амны зүүн талд Жимс, жимсгэний зориулалтаар 94 га газарт газар эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах А/193 дугаар захирамжийн дагуу төсөл сонгон шалгаруулалтанд оролцсон 21 иргэн, аж ахуйн нэгжээс 12 иргэн, аж ахуйн нэгжид 99 га газар олгох шийдвэр гарсан.

10. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд бизнес инкубацийн үйлчилгээг үзүүлэх, тэдгээрийг бойжуулах, хөнгөлөлттэй зээлд хамруулах ажлыг нийслэлийн холбогдох нэгжүүдээр дамжуулан гүйцэтгүүлэх

- Улсын Зээлийн батлан даалтын сангаас 2016 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн хэмжээнд өссөн дүнгээр 266 жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэнд 62.1 тэрбум төгрөгийн зээл авах боломжийг бүрдүүлж, 24.2 тэрбум төгрөгийн батлан даалтыг гаргасан. Үүний үр дүнд 2172 ажлын байрыг хадгалж, 885 ажлын байрыг шинээр бий болгосон.

- Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв НӨҮГ-тай хамтран “Нийслэл ЖДҮ 2016” жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн 3 дугаар зөвлөгөөнийг 2016 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Нийслэлийн Иргэний танхимд зохион байгууллаа. Зөвлөгөөнд 410 ЖДҮ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж оролцсон бөгөөд Нийслэлийн ЖДҮ-ийг хөгжүүлэх чиглэлээр баримтлаж буй бодлого, цаашдын зорилт, үйл ажиллагааны талаар, санал бодлоо солилцон дэд хөтөлбөрт тусгах саналыг авч, зөвлөмж гаргасан.

- Жижиг, дунд, өрхийн үйлдвэр эрхлэгчдэд аж ахуйн ур чадвар эзэмшүүлэх, чадавхижуулах зорилгоор Тэсо группийн Айсмарк зайрмаг болон Милко, Зөв аарцны ундааны үйлдвэртэй танилцах, туршлага солилцох сургалтыг 2016 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Чингэлтэй дүүргийн Үйлдвэр үйлчилгээний хэлтэстэй хамтран зохион байгууллаа. Энэхүү ажлын хүрээнд нийслэлд хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 90 гаруй

аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн төлөөллийг үйлдвэрийн үйл ажиллагаа, шинэ техник технологитой танилцуулж, цаашид хамтран ажиллах талаар санал бодлоо солилцлоо.

- 2016 оны хаврын тариалалтанд зориулан Хөгжлийн банкнаас олгох хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломжтой иргэд аж ахуйн нэгжийн судалгааг ХХААЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлэв.

11. Малын үүлдэр угсааг сайжруулж ашиг шимийг нэмэгдүүлэхэд биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх ажлыг төрийн захиргааны төв болон салбарын шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран зохион байгуулах

- Малын үржлийн ажлын чиглэлээр 2016 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулж, батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Үржлийн "Шилмэл сүрэг" хоршоотой зохиомол хээлтүүлгийг захиалгын дагуу гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж, жилийн эцсийн байдлаар 281 үнээ, мах- өөхний чиглэлийн Эдейлбай үүлдрийн 600 хонинд зохиомол хээлтүүлэг хийж, хээл авалт 85 хувьтай байна.

Малын өвчин гарсантай холбогдуулан улсын хэмжээнд "Шилмэл мал-2016" үзэсгэлэнг аймаг, орон нутагтаа зохион байгуулах чиглэл салбарын яамнаас өгсний дагуу Нийслэлийн "Шилмэл мал-2016" арга хэмжээг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газартай хамтран тус дүүргийн 21 дүгээр хороонд 09 дүгээр сарын 20-нд зохион байгуулж, үзэсгэлэнд сүүний 23 үхэр, мах-сүүний хосолмол ашиг шимт үхэр 5, аж ахуй нэгж 3 оролцож шалгаруулалтыг явуулж, шагнаж урамшууллаа.

12. Мал, тэжээвэр амьтны тэжээлийн үйлдвэрлэл эрхлэхийг бүх талаар дэмжиж ажиллах

- "Тэжээл" дэд хөтөлбөрийн төслийг боловсруулж холбогдох хууль, журамтай нийцүүлэн хөтөлбөрийн төслийг 8 бүлэгтэйгээр боловсруулан НИТХ-ын А/232 тоот тогтоолоор батлуулж ажиллалаа. Энэ ажлын хүрээнд Багануур дүүрэгт "Тэжээлийн ургамал тариалах" технологийн сургалтыг ХХААЯ-тай хамтран зохион байгууллаа. Уг сургалтад 50 гаруй хүн хамрагдаж сургагч багшийн сертификат авлаа. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар Нийслэлийн Засаг даргын 02 дугаар албан даалгаврыг гаргуулан мал бүхий дүүргүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг хангах талаар чиглэл өгч ажиллалаа.

Мөн 2016 оны 02 дугаар сарын 1-ээс 7-ны өдрүүдэд Норвеги Улсын Осло хотын Био эдийн засгийн судалгааны институтын зохион байгуулсан "Тэжээлийн чанар, малын эрүүл ахуй болон малын ген-тогтвортой сүргийн өсөлт хөгжилт" олон улсын семинарт оролцож, фермийн аж ахуйн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалан ажиллалаа.

13. Мал сүргийг индексжүүлж, им, тамгажуулах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах

"Нийслэлийн "Монгол мал" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2016 оны ажлын төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Бүртгэлжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр УМЭҮГ, НМЭГ болон мал бүхий 6 дүүргийн ЗДТГ, МЭҮҮН-тэй хамтран ажиллалаа.

"Монгол мал" дэд хөтөлбөрийг 2021 он хүртэл хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан ажиллалаа. Малчны тамга, тэмдгийн захиалгыг мал бүхий 6 дүүргээс авч нэгтгэн Мал хамгаалах санд хүргүүллээ. Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн нийгэм, эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын саналыг тусган холбогдох газарт хүргүүлэн ажиллалаа. 2015 оны арьс, ширний урамшуулалд 128 малчны 29.263.860, ноосны урамшуулалд 267 малчны 69569.7 кг ноосонд урамшуулал олгогдохоор материалыг бүрдүүлж,

ХХААХҮЯ-нд хүргүүллээ. Урамшуулалд хамрагдах малчдын материалд тулгалт хийж, программд оруулан ХХААЯ-ны Мал хамгаалах санд хүргүүллээ.

14. Усалгаатай газар тариаланг өргөжүүлэх ажиллагааг эрчимжүүлэх, хамгаалагдсан хөрсний /хучлагатай талбай, хүлэмж/ болон төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх

- “Монгол ногоо” төслийн нэгжтэй хамтран нийслэлийн 3 дүүргийн 4 байршилд газар тариалангийн зориулалтаар гүний худаг гаргаж, жишиг гудамжуудын өрхүүдэд нэгдсэн усалгааны хоолой байршуулж өглөө. Мөн Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах төслийн хүрээнд СХД-ийн 21 дүгээр хороо Шар хоолойн аманд 2 ширхэг инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах ажлыг хариуцан ажиллалаа.

15. Өрх бүрийг хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах хөдөлгөөнд хамруулж, өрхийн тариаланг дэмжих зорилгоор төмс, хүнсний ногооны үр, үрслэг, жимсний суулгац, тарьцыг хөнгөлөлттэй үнэ болон зээлээр нийлүүлэх, суулгац үйлдвэрлэх санаачилгыг дэмжин туслах

- 2016 оны хаврын тариалалтанд зориулан ХХААЯ-наас 10 кг шар манжин, 22 кг хүрэн манжин, 500 кг төл сонгины үрийг хүлээн авч нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын тамгын газар, 6 агропарк, НҮХААГ-т хүсэлт тавьсан иргэд аж ахуйн нэгжүүдэд технологийн зөвлөмжийн хамт олгож байна. Мөн чацарганы суулгац зээлээр авч тариалах хүсэлт гаргасан иргэд, аж ахуйн нэгжийн хүсэлтүүдийг судлаж ХХААЯ-ны Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 9000 ширхэг чацарганы суулгацыг авч 1 аж ахуйн нэгж, 4 иргэнд гэрээ байгуулан олголоо.

16. Байгаль орчин, бүтээгдэхүүний чанарт сөрөг нөлөөгүй аргаар тариалангийн хог ургамал, өвчин, хортон шавьж, мэрэгчидтэй тэмцэх арга ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах

- Багануур дүүргийн Засаг даргын тамгын газрын хүсэлтээр 2016 оны 03 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд дүүргийн иргэдэд газар тариалангийн чиглэлээр сургалт зохион байгууллаа. Сургалтанд тус дүүргийн 48 иргэн хамрагдсан бөгөөд Төлөвлөлт, үр ашиг, Үрийг тарилтанд бэлтгэх, Хөрс боловсруулалт, Багсармал бордоо бэлтгэх, Талбайг бордох, Дарлага, хүлэмж, гэрийн нөхцөлд үрслэг тарих, ургалтын үед хийх арчилгаа, шилжүүлэн суулгах, Нийлэг болон шилэн хүлэмжийн бүтэц, зохион байгуулалт, Төмс хүнсний ногоо тариалах технологи, арчилгаа хадгалалт, Гүзээлзгэнэ тариалах технологи, Органик болон химийн аргаар хог ургамал, хортон шавьжтай тэмцэх талаар мэдлэг олгохоос гадна үр дэвээх, тарих, үрслэг тарих, шилжүүлэн суулгах арга ажиллагааг харуулсан дадлага хичээл зохион байгууллаа.

- “Монгол ногоо” төслийн хүрээнд “Төмс, хүнсний ногооны тариалалт хэрэглээний цогц мэдлэг олгох” шаталсан сургалтанд нийслэлийн 9 дүүргийн 465 иргэнийг хамруулж, өрх толгойлсон болон хөгжлийн бэрхшээлтэй 154 иргэдэд 7 төрлийн хүнсний ногооны үр тараан олгосон. Төслийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 24-р хорооны 15 өрх, 25-р хорооны 11 өрх, Хан-уул дүүргийн 10-р хорооны 12 өрх, Налайх дүүргийн 7-р хорооны 23 өрхийг жишиг гудамж болгохоор нийт 61 өрхийг сонгож үр үрсэлгээ болон 4*8 харьцаатай хүлэмжийг олголоо. Мөн ЭКО сургууль, цэцэрлэг болгохоор Сонгинохайрхан дүүргийн 65-р сургууль, 117-р цэцэрлэг, Хан-уул дүүргийн 34-р сургууль, 71-р цэцэрлэг, Налайх дүүргийн Голомт цогцолбор сургууль, 123-р цэцэрлэгийг төслийн баг сонгож 6*8 харьцаатай хүлэмж үр үрсэлгээ олголоо.

ДӨРӨВ. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

4.1. Үйл ажиллагааны ил тод байдал

Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай НЗД-ын 2012 оны 606 дугаар захирамжийн дагуу байгууллагын цахим хуудсанд дараах мэдээллүүдийг байршууллаа. Үүнд:

- Газрын даргын тушаал
- Хүний нөөц
- Төсөв санхүү
- Тайлан, төлөвлөгөө
- Төсөл хөтөлбөр
- Худалдан авалт
- Өргөдөл гомдлын шийдвэрлэлт
- Хууль, эрх зүй
- Шилэн данс
- Төрийн үйлчилгээ
- Төрийн үйлчилгээ гэх мэт мэдээллийг тухай бүр тогтмол баяжуулж, цахим хуудасны хэвийн үйл ажиллагааг хангах ажиллаж байна.

Мөн иргэдэд байгууллагаас иргэдэд үзүүлдэг төрийн үйлчилгээ-14, зөвлөмж-11, бусад мэдээ-36 мэдээллийг байгууллагын цахим хуудас, [facebook.com/hhaag.ub.gov.mn](https://www.facebook.com/hhaag.ub.gov.mn) хуудсаар тус тус дамжуулан хүргэж байна.

4.2. Хэрэглэгчийн үнэлгээ

2016 онд үндсэн ажил үйлчилгээний чиг хандлагыг тусгасан 4 асуулт бүхий хуудсыг шинэчлэн боловсруулж, үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас нийт 183 санал ирүүлсэн байна. Ирүүлсэн саналуудын 21 хувь нь үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх, 25 хувь нь ХАА-н сургалт авах хүсэлтэй байгаагаар илэрхийлсэн бол 17 хувь нь мэдээллийг хүртээмжтэй, түргэн шуурхай авах, хөнгөлөлттэй зээл тусламжид хамрагдах төлөв хөтөлбөрт хамрагдах, 29 хувь нь техник тоног төхөөрөмж хөнгөлөлттэй үнээр авах, 12 хувь нь нарийн ногооны үр авах саналтай байна. Хүлэмжийн үйлдвэрлэл эрхлэн газар тариалангийн үйлдвэрлэлийг үр бүтээлтэй эрхлэх хүсэл сонирхол ихтэй, хүлэмжийн аж ахуйг түлхүү хөгжүүлэн нэгж талбайгаас хураан авах ургацын хэмжээг нэмэгдүүлж, энэ чиглэлээр мэдлэг авах, санхүүгийн дэмжлэг нэлээд шаардлагатай байгаа ба газар тариалан эрхлэгчид энэ салбарт хэрэгжиж буй зээл, төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэн тариалах, төсөл бичих аргачлалын мэдлэг олгох зэрэг саналууд ирсэн байна. Байгууллагын цахим хуудсыг шинэчлэн ажиллуулж эхэлснээс хойш нийт 23171 хүн зочилж байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг авсан байна. Нийт 127 хүн байгууллагын үйл ажиллагааны талаар санал өгснөөс 50% маш сайн, 25% нь хангалттай, 24% хангалтгүй үнэлгээг өгсөн байна. Хэрэглэгчийн үнэлгээний 2016 оны дэлгэрэнгүй тайлан боловсруулж холбогдох газарт хүргүүлсэн болно.

ТАВ.Бусад мэдээлэл

5.1 Хүний нөөцийн ил тод байдал

- Хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний программд албан хаагчдын мэдээллийг оруулж, тайланг Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлээ.
- Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, бүрэлдэхүүн хөдөлгөөний 2016 оны тайланг гаргаж, Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 2017 оны 01 дүгээр сарын 05-ны 01/02 албан бичгээр хүргүүлэв.

- Байгууллагын цахим хуудсанд хүний нөөцийн ил тод байдал цэс үүсгэн тухай бүрт шинэчлэн мэдээ мэдээллээр баяжуулж байна. Үүнд:
 - Хагас бүтэн жилээр албан хаагчдын үр дүнгийн гэрээ дүгнэсэн байдал
 - Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр
 - Ажлын байр, орон тоо /2016 онд нээлттэй ажлын байр зарлагдаагүй/
 - Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт

Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/644 дүгээр захирамжийн 1 дүгээр хэсэгт заасны дагуу мэргэжилтэн Б.Ганцэцэг, Ж.Содцэцэг, Ч.Чулуунцэцэг, Ц.Төмөрбаатар, Ц.Буянжаргал, Д.Энхцэцэг нарыг Газрын даргын 2016 оны Б/23 тушаалаар Үйлдвэрлэл, инновацийн газарт шилжүүлж, хувийн хэрэг, нийгмийн даатгалын дэвтрийг хүлээлгэж өгсөн. Тус захирамжийн 2 дугаар хэсгийн 2.2-т заасны дагуу манай байгууллага нь өөрчлөлт хийж, бусад албан хаагчдаа чөлөөлж, шинэ бүтцээр томилов зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтөөр үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдад холбогдох хууль тогтоомжийн дагуу нэг удаагийн тэтгэлэг олгож, нийгмийн даатгалын болон татварын байгууллагуудтай тооцоо хийж дуусгав.

2016 оны 10 дугаар сарын 27-ны Нийслэлийн Засаг даргын А/758 захирамж “Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дүрэм”-ийг албан хаагчдад танилцуулан дүрэм батлагдсантай уялдуулан 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/19 тушаалаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журам батлав.

5.2 Цаг үеийн ажлын онцлогтой холбогдох бусад мэдээлэл

Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч орлогчийн 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрүүдэд тулгамдаж байгаа асуудлын тухай санал асуулгыг 02 дугаар сарын 25-ны өдрөөс 03 дугаар сарын 16-ны өдрүүдэд идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа 250 үйлдвэрийг хамруулан явуулсан. Судалгааны дүнг нэгтгэн, тайлан мэдээг 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хуралд танилцууллаа.

Энэхүү судалгаагаар үйлдвэрлэл эрхлэгчдэд чухамхүү ямар төрлийн хүндрэл, бэрхшээл хамгийн ихээр тулгарч байгааг аж үйлдвэрийн салбаруудаар нь тогтоож, түүнд нөлөөлж буй шалтгаануудыг илрүүлэх, эдийн засгийн өнөөгийн нөхцөлд төрийн болон үйлдвэрлэл эрхлэгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэн аж үйлдвэрийн салбарт үзүүлэх дэмжлэгийг үр өгөөжтэй болгох, тулгамдаж буй асуудлыг хамтран шийдвэрлэхэд судалгааны зорилго оршиж байлаа.

Нийслэлийн хүн амыг хямд үнэтэй, дотоодын үйлдвэрлэлийн төмс, хүнсний ногоогоор хангах зорилгоор Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар, “Монгол төмс” хөтөлбөртэй хамтран “Үйлдвэрлэгчээс хэрэглэгчид” уриан дор төмсний үнэ тогтворжуулах 2 сар зохион байгууллаа. Тус худалдаагаар 5 дүүргийн 16 байршилд борлуулалт хийж нийт 310 мянган тонн төмс, 30 тонн шар лууван, 6 тонн шар манжин, 3 тонн сонгино нийт 246,6 сая төгрөгний борлуулалт хийсэн байна.

Улаанбаатар хотын иргэдийн төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах, хүнсний ногоо, жимс, жимсгэний аж ахуй эрхлэгчдийг дэмжих, иргэдэд эрүүл, баталгаатай хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх зорилгоор жил бүрийн 8 дугаар сарын 25-аас 10 дугаар сарын 25-ны өдрүүдэд “Алтан намар үзэсгэлэн худалдаа”-г зохион байгуулж. Нийслэлийн 6 дүүргийн 49 байршил 500 гаруй цэгт орон нутгийн болон дүүргүүдийн ногоочид 421 тонн төмс, 265 тонн хүнсний ногоо, 14051 шил даршилж нөөшилсөн өргөст хэмх, улаан лооль, 3045 кг зөгийн бал, 5-6 нэр төрлийн эмийн болон гоёл чимэглэлийн 2500 гаруй мод буцыг худалдаж 555,1 сая төгрөгний борлуулалт хийсэн байна.

Монгол Улсад худалдааны салбар үүсч хөгжсөний 95 жилийн ойд зориулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран “Улаанбаатар түншлэл – 2016” намрын үзэсгэлэн, яармагийг 2016 оны 09 дүгээр сарын 08-аас 11-ний өдрүүдэд “Мишээл Экспо” төвд 4 хоног зохион байгуулагдсан бөгөөд дотоодын 110 аж ахуйн нэгж, байгууллага, бизнес эрхлэгчид оролцсоноос Хүнсний салбарын 39 аж ахуйн нэгж, Эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 9 аж ахуйн нэгж, хөнгөн үйлдвэрийн салбарын 30, ном, бичгийн хэрэгслийн 3, үнэт эдлэлийн 3, барилгын салбарын 3, бусад төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 2, импортын бүтээгдэхүүн үйлчилгээний 21 аж ахуйн нэгж, байгууллагууд тус тус оролцож 157,7 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Үзэсгэлэнг зохион байгуулах хорооноос шилдгийн шилдэг байгууллагуудаа шалгаруулсан. Тус үзэсгэлэнгийн Алтан түншээр “Жүр үр” ХХК, “Глобал Трейдинг Девелопмент” ХХК, Ерөнхий ивээн тэтгэгчээр “Батбайгаль” ХХК, ивээн тэтгэгчээр “Алтан тос” ХХК-иуд тус тус хамтран ажиллалаа.